

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2025

АГУУЛГА

- 1 ТАЙЛАНГИЙН ТУХАЙ
- 2 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ
- 3 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ
- 4 БИДНИЙ ТУХАЙ
- 5 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
- 6 СТРАТЕГИ
- 7 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО
- 8 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
- 9 ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ
- 10 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
- 11 ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ
- 12 ТАЙЛАГНАЛ
- 13 ХАВСРАЛТ



ТАЙЛАНГИЙН ТУХАЙ

Төрийн банкны эрхэм зорилгод "...Байгаль орчинд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай, ил тод сайн засаглалтай, ногоон хөгжил, дундаж давхаргыг бойжуулах, дэмжих..." чиглэлийг тодотгон оруулж өгсөн.

Бид тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм, засаглал болон ногоон хөгжлийн чиглэлээр сүүлийн жилүүдэд илүү идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд энэ чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааны 2025 оны тайланг оролцогч талуудад ийнхүү ил тод, нээлттэй тайлагнаж байна.

Энэхүү Тогтвортой хөгжлийн тайлан нь Төрийн банкны өмнөх тайлант хугацааны үйл ажиллагааны хүрээнд эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлсэн нөлөө, хэрэгжүүлсэн бодлого, гүйцэтгэлийг олон нийтэд ил тод, ойлгомжтой тайлагнах зорилготой. Банк нь тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг үйл ажиллагаандаа системтэйгээр нэвтрүүлж, урт хугацаанд хариуцлагатай, тогтвортой өсөлтийг дэмжих стратегийг баримталж байна.

Тус тайланд Төрийн банкны 2025 оны санхүүгийн жилийн үйл ажиллагааг хамруулан, Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын чиглэлийн бодлого, үйл ажиллагаа, гол гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тусгав. Тайланг боловсруулахдаа Олон улсын тогтвортой байдлын тайлагналын арга аргачлал, стандартын шаардлага, зарчмуудыг баримталж, үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичиг болон олон улсын шилдэг туршлагуудтай уялдуулан бэлтгэлээ.

Төрийн банк нь тогтвортой хөгжлийн тайлагналаа жил бүр тасралтгүй сайжруулж, өгөгдөл цуглуулалт, хэмжилт, ил тод байдлыг бэхжүүлэхийг зорин ажиллаж байна. Цаашид уур амьсгалын эрсдэл, нийгмийн нөлөөлөл, засаглалын тогтолцоотой холбоотой мэдээллийг илүү нарийвчлан тайлагнах, олон улсын санаачилгуудтай уялдуулахад илүү ахиц гарган ажиллахаар төлөвлөж байна.

Та бүхэн Төрийн банкны Тогтвортой хөгжлийн тайлан болон БОНЗ-ын тайлантай холбоотой санал, хүсэлтээ sd@statebank.mn хаягаар ирүүлэх боломжтой.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан Та бүхэнд “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс мэндчилгээ дэвшүүлж, 2025 оны “Тогтвортой хөгжлийн тайлан”-гаа өргөн барьж байна.

Тайлант хугацаанд бид тогтвортой санхүүжилт, ногоон хөгжил, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтыг харилцагч төвтэй үйлчилгээг дэвшилтэт цахим шийдэлтэй уялдуулан хэрэгжүүлж, байгаль орчин, хүний эрх, нийгмийн хариуцлага, сайн засаглалын зарчимд нийцсэн үйл ажиллагааг үе шаттай бэхжүүлэн ажиллалаа.

Ногоон болон хариуцлагатай санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, үр нөлөөллийн хэмжилт, тайлагналын чанарыг сайжруулах, уур амьсгалтай холбоотой эрсдэлийг илүү системтэй удирдах чиглэлээр бодит ахиц гаргасны зэрэгцээ мэдээллийн болон үйл ажиллагааны

тогтвортой байдлыг хангах зорилгоор олон улсын стандартууд нэвтрүүлж, мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлагыг бэхжүүллээ. Эдгээр санаачилга нь тогтвортой үйл ажиллагааны суурь нөхцөлийг улам баталгаажуулсан гэж үзэж байна.

Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтын хэрэгжилтийг хангах чиглэлээр Төлөөлөн удирдах зөвлөлөөс засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын арга хэмжээг тогтмол хэлэлцэж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Бид цаашдын үйл ажиллагаандаа тогтвортой санхүүжилт, ногоон хөгжлийг дэмжих бүтээгдэхүүн, үйлчилгээг үе шаттай нэвтрүүлж, байгаль орчин, хүний эрх, нийгмийн хариуцлагын зарчимд нийцсэн үйл ажиллагааг гүнзгийрүүлэх, ил тод тайлагнал болон үр нөлөөллийн үнэлгээний чанарыг дээшлүүлэхэд түлхүү анхаарч ажиллана.

Та бүхний итгэл, дэмжлэг, хамтын ажиллагаанд талархал илэрхийлж, хамтдаа илүү тогтвортой, хариуцлагатай ирээдүйг бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн:

Г.ЗОЛБОО

ТУЗ-ИЙН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

*Эрхэм хүндэт харилцагчид,
хувьцаа эзэмшигчид,
хамтран ажиллагч
байгууллагууд, эрхэм
ажилтнууд Та бүхэнд энэ
өдрийн мэндийг өргөн
дэвшүүлье.*



Төрийн банкны 2025 оны Тогтвортой хөгжлийн тайланг Та бүхэнд хүргэж буйдаа баяртай байна. Бид өнгөрсөн онд санхүүгийн тогтвортой өсөлтийг хангахын зэрэгцээ байгаль орчин, нийгэм, засаглалын хариуцлагыг бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарлаа.

Бид 2025 онд олон улсын зах зээлд 200 сая ам.долларын бондыг гурван жилийн хугацаатайгаар Сингапурын хөрөнгийн биржээр дамжуулан амжилттай арилжааллаа. Энэхүү бондыг олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчид идэвхтэй сонирхон оролцож, захиалга зорилтот дүнгээс давсан нь манай банкны засаглал, ил тод байдал, тогтвортой хөгжлийн бодлогод итгэж буйн тод илэрхийлэл боллоо.

Мөн “Тогтвортой өсөлт, хамтын түншлэл” цуврал арга хэмжээг зохион байгуулж, 200 гаруй компанийн төлөөллийг нэгтгэн, тогтвортой хөгжлийг түүчээлэн манлайлж буй компаниудын экосистемийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулав.

Тогтвортой санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд бид ногоон харилцах дансны үйлчилгээг зах

зээлд нэвтрүүлж, тогтвортой хөгжлийг дэмжигч иргэн, аж ахуйн нэгжүүдэд зориулсан урамшуулалт нөхцөлийг бүрдүүллээ. Мөн Бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, тогтвортой хөгжилд чиглэсэн бизнесийн төслүүдийг санхүүжүүлэх зорилготой Бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.

Түүнчлэн ногоон орон сууцны зээлийг шинээр нэвтрүүлж, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг өргөжүүлэв. 2025 оны 7 дугаар сараас нийтийн зориулалттай орон сууцыг уг зээлд хамруулах шийдвэр гаргасан нь илүү олон өрхөд эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй шийдлийг сонгох боломжийг нээж өгсөн юм.

Цахим шилжилт, инновацад тулгуурлан харилцагч бүрд илүү хүртээмжтэй, шуурхай, аюулгүй үйлчилгээг хүргэхийн зэрэгцээ цаасны хэрэглээг бууруулах, дотоод үйл ажиллагааны үр ашиг, нөөцийн зохистой хэрэглээг сайжруулах бодит алхмуудыг хэрэгжүүлэв. Нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрүүдийг өргөжүүлж, байгаль орчинд ээлтэй хэрэглээ, ногоон хөгжил, хариуцлагатай санхүүгийн талаарх ойлголтыг түгээхэд анхаарч ажиллалаа.

Эдгээр алхмууд нь бидний тогтвортой хөгжлийн стратеги бодитоор хэрэгжиж, ногоон санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, хамтын үнэ цэнийг бий болгох зорилго тууштай хэрэгжиж буйн илрэл юм.

Бид урт хугацаанд тогтвортой өсөлтийг хангахын зэрэгцээ байгаль орчинд ээлтэй, нийгэмд хүртээмжтэй, засаглалын өндөр стандарт бүхий банк байх зарчмаа баримтлан ажиллах болно. Ирээдүйн үнэ цэнийг хамтдаа бүтээж буй Та бүхэндээ гүн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн:

Ө.ГАНТӨР

**ТӨРИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

БИДНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Сангийн сайдын 2009 оны 259 дүгээр тушаалын дагуу банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчид болон харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор 100 хувь төрийн өмчит Төрийн банкийг байгуулах шийдвэр гарсан. Уг шийдвэрийг хэрэгжүүлж, Банкны тухай хууль болон холбогдох журамд үндэслэн “Төрийн банк” ХК 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан бөгөөд банкны салбарт 17 дахь жилдээ тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

“Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн хүрээнд “Төрийн банк” ХК нь системийн нөлөө бүхий банкуудаас нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн анхдагч банкуудын нэг юм. Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн дагуу Төрийн банк Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлэн нийт хувьцааны 5.71 хувийг олон нийтэд санал болгон амжилттай арилжаалсан. Ийнхүү нийт 7,421 хөрөнгө оруулагчаас 25.4 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлж, нээлттэй хувьцаат компанийн засаглалын шинэ шатанд шилжсэн.

Өнөөдөр Төрийн банк улс даяар 500 орчим салбар, нэгжээр дамжуулан 2.3 сая харилцагчид дэвшилтэт цахим технологид тулгуурласан хүртээмжтэй, тогтвортой санхүүгийн үйлчилгээг хүргэж байна. Банк нь байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод засаглалд суурилсан үйл ажиллагааг эрхэмлэж, ногоон хөгжил болон дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн санхүүгийн шийдлүүдийг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Төрийн банк 2025 оны байдлаар 6.7 их наяд төгрөгийн нийт хөрөнгөтэй бөгөөд өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар зэрэг Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны

шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган, санхүүгийн тогтвортой байдлаа хадгалан ажиллаж байна.

“Төрийн банк” ХК Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу дараах үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

- Мөнгөн хадгаламж
- Зээл
- Төлбөр тооцоо
- Гадаад валют худалдаж авах, худалдах, хадгалах, хадгалуулах
- Үнэт металл, эрдэнийн чулуу худалдаж авах, худалдах, хадгалах, хадгалуулах
- Үнэт зүйл хадгалах
- Гадаад төлбөр тооцоо хийх
- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах
- Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх
- Даатгалын зуучлалын үйлчилгээ
- Эх үүсвэртэй баталгаа, батлан даалт гаргах
- Эх үүсвэргүй баталгаа, батлан даалт гаргах
- Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа,
- Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах.

Төрийн Банк нь банкны салбарын зохистой бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байна. Монгол Улсын банкны салбарын ТОП 5 банкны нэгээр дахин шалгарч, олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Moody's агентлаг Төрийн банкны зээлжих зэрэглэлийг “B2”-оос “B1” болгон сайжрууллаа.

Бид нэгдмэл байдал, багаар ажиллах чадвар, харилцан хүндлэл, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлсээр байна.



**ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ЗӨРИЛГО**

АЛСЫН ХАРАА

Дундаж давхаргыг дэмжигч,
үндэсний тэргүүлэгч банк байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгаль орчинд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, ногоон хөгжил, дундаж давхаргыг бойжуулах, дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт цахим технологи ашиглан тогтвортой, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

ҮНЭТ ЗҮЙЛС



ИТГЭЛЦЭЛ

Итгэл, Сэтгэл,
Хүндлэл



ХАРИУЦЛАГА

Сахилга бат,
Сайн үр дүн



УР ЧАДВАР


Хүний хөгжил,
Хөгжлийн
түлхүүр



ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ

Шилэн банк

ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төрийн банк нь Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого болон Тогтвортой хөгжлийн журмыг олон улсын жишиг, стандарттай нийцүүлэн шинэчилж, тогтвортой хөгжлийн чиг үүргийг банкны бүтэц дэх бие даасан нэгжээр хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлсэн. Бид Тогтвортой хөгжлийн хорооны түвшинд ногоон хөгжил, ногоон эдийн засгийн асуудлыг тогтмол хэлэлцэж, шийдвэрлэх замаар засаглалын тогтолцоогоо бэхжүүллээ.

Хувьцаа эзэмшигчид

“Төрийн банк” ХК-ийн хувьцааг Сангийн яам 49.26 хувь, Хадгаламж даатгалын корпораци 45.03 хувь, олон нийт 5.71 хувийг тус тус эзэмшиж байна.

- Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу 2025 оны “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай тайлан, хувьцаа эзэмшигчдэд 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулж, “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг тус тус хэлэлцэж шийдвэрлэлээ.
- “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу зохион байгуулж, хурлын тэмдэглэл, шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын саналын эрхийн тооллогын баримт бичгийн баталгаажуулсан хувийг 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монголбанканд хүргүүлэв.



Төлөөлөн удирдах зөвлөл

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын 05 дугаар тогтоолоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг олон улсад хэрэгжиж буй засаглалын сайн практик, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д тус тус нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Шинэчлэгдэн батлагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу Төлөөлөн

удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн ээлжит хурал сар бүр тогтмол, шаардлагатай нөхцөлд тухай бүр хуралдаж, банкны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, банкны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлах, зохистой засаглалын болон эрсдэлийн удирдлагын бодлого, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлттэй танилцах, батлах, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх, ТУЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

ТУЗ нь 2025 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 11 удаа хуралдаж, 67 асуудал хэлэлцэн

шийдвэрлэж, 10 үүрэг даалгавар, 99 тогтоол тус тус гаргаж, ТУЗ-ийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлсэн.

“Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгчээр Г.Золбоо, гишүүнээр Б.Ганбат, Х.Пүрэвсүрэн, хараат бус гишүүнээр М.Батжаргал, С.Цэнд-Аюуш, З.Оюунцацрал, Б.Цэвэгжав нар томилогдож, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон “Төрийн банк” ХК-ийн дүрэмд заасан ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлж, банкны үйл ажиллагааны хэвийн тогтвортой байдлыг ханган, стратеги, бодлого, эрсдэлийн удирдлага, санхүүгийн хяналтын чиглэлээр шийдвэр гарган ажиллалаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгч

Г.Золбоо

Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга

МУИС-ийн Эдийн засгийн сургуульд банкны эдийн засагчаар бакалавр, ИБУИНВУ-ын Уэльсийн их сургуульд олон улсын бизнесийн менежментийн чиглэлээр боловсрол эзэмшсэн. 2013-2024 оны хооронд Сангийн яаманд зөвлөх, хэлтсийн дарга, газрын даргаар ажилласан туршлагатай.

ТУЗ-ийн гишүүд



Б.Ганбат

ТУЗ-ийн гишүүн, Засгийн газрын
Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх.

ЗХУ-ын Дотоод явдлын яамны Академийн хууль эрх зүйн бакалавр, ИБУИНВУ-ын Коммонвелт хуулийн коллежид хууль эрх зүйн магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 1995-2016 онд Сангийн яаманд хуулийн зөвлөх, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн,

хэлтсийн дарга, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, газрын орлогч дарга, газрын дарга, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт газрын дарга, Тэргүүн дэд даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат хуульч.



Х.Пүрэвсүрэн

ТУЗ-ийн гишүүн

МУИС-д нягтлан бодогч, эдийн засагч магистр, Голланд Улсын Маастрихтийн менежментийн их сургуульд нягтлан бодох, эдийн засгийн менежментийн чиглэлээр тус тус боловсрол эзэмшсэн.

1992-1996 онд СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, 1996-1997 онд "Говь" ХК-д эдийн засгийн хэлтсийн дарга, 1997-1999 онд Төрийн өмчийн хороонд албаны

дарга, 1999-2016 онд Сангийн яаманд газрын дарга, Сангийн сайдын зөвлөхөөр ажиллаж байсан ажлын туршлагатай.



С.Цэнд-Аюуш

ТУЗ-ийн хараат бус гишүүн, Санхүүч

ОХУ-ын Эрхүү хотын Улс ардын аж ахуйн дээд сургуульд санхүүч мэргэжлээр боловсрол эзэмшиж, бакалаврын зэрэг хамгаалсан. 1978-2015 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.



М.Батжаргал

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Хөдөө аж ахуйн дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр бакалавр, эдийн засгийн ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн.

1975-1989 онд Улсын банканд эдийн засагч, орлогч дарга, Увс аймгийн Ерөнхий арбитрч,

1993-2008 онд Монголбанканд газрын захирал, ерөнхий захирал, ахлах ажилтан, ахлах хянан шалгагч,

Хяналт шалгалтын хэлтсийн захирал, Дотоод аудитын газрын ахлах хянан шалгагч, аудитын зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.



З.Оюунцацрал

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эдийн засгийн коллежийг банк, зээлийн эдийн засагчаар бакалавр, БНСУ-ын Хандонг глобал их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэг, СЭЗИС-ийн удирдахуйн ухааны доктор зэрэгтэй. 1996 оноос өнөөг хүртэл СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, профессороор ажилласан туршлагатай.



Б.Цэвэгжав

ТУЗ-ийн хараат бус гишүүн

СЭЗИС-д банкны удирдлагын бакалавр, МУИС-ийн Эдийн засгийн сургуульд бизнесийн удирдлагын магистр зэргээр тус тус боловсрол эзэмшсэн.

2002-2014 онд Капитрон банканд нягтлан бодогч, эдийн засагч, дилер, салбарын захирал, 2014-2015 онд Богд банк байгуулах төсөл, хөрөнгийн удирдлага

хариуцсан гишүүн, 2015-2017 онд "Мегамакс групп" ХХК-д санхүү хариуцсан захирал, 2017-2023 онд "Эрдэнэс Монгол" ХХК-д албаны дарга, хэлтсийн дарга, 2022-2023 онд "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн дарга, "Эрдэнэс силвер ресурс" ХХК, "Гашуун сухайт авто зам" ХХК, "Метан газ ресурс" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан ажлын туршлагатай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Холбогдох хууль тогтоомж, банкны дүрмийн хүрээнд ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороог ажиллахаар тогтоож, шаардлагатай нөхцөлд цаг үеийн шинжтэй болон бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулан ажиллаж байна.

ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журамд Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан "Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам", Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлагуудыг тусгасан бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороод нь Банкны тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, "Төрийн банк" ХК-ийн дүрэм болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад хэм хэмжээг мөрдөн ажиллаж байна.

Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэг, Монголбанкнаас баталсан "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам", Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын

кодекс"-ын дагуу 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолоор хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор Аудитын хорооны бүрэлдэхүүнийг, 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 56 дугаар тогтоолоор Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнийг тус тус шинэчлэн баталсан.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Эрсдэлийн удирдлын хороо, Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хороог ТУЗ-ийн хараат бус гишүүд даргалж байна.



Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, ТУЗ-өөс баталсан банкны стратеги төлөвлөгөө, банкны бодлогын хэрэгжилт, банкны үндсэн үйл ажиллагааны явцад хийгдэх гүйцэтгэлийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудал, түүний үнэн бодит байдалд хяналт тавих, банкны дотоод болон хөндлөнгийн аудитын цар хүрээг тодорхойлох, үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, хөндлөнгийн болон дотоод аудит, комплайнсын хяналтын хараат бус байдлыг баталгаажуулах, хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж байгаа талаарх хэрэгжилтийн үр дүнг хангах чиглэлээр ажиллаж байна.

Аудитын хорооны ээлжит хурал улирал бүр тогтмол зохион байгуулагдаж, 2025 онд нийт 23 удаа хуралдан, 54 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 55 шийдвэр гарган, 32 үүрэг даалгавар өгч, ТУЗ-ийг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн, хорооны эрх үүргийг хэрэгжүүллээ.

Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны үйл ажиллагааны чиглэл бүрд үүсэж болох эрсдэлийн түвшнийг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах зэргээр эрсдэлийн оновчтой, шуурхай, хараат бус удирдлагыг хэрэгжүүлэх, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, банкны зохистой, чадварлаг, мэргэшсэн эрсдэлийн удирдлага, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх, банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлыг улирал бүр тогтмол зохион байгуулж, 2025 онд нийт 14 удаагийн хурлаар 49 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 32 шийдвэр гарган, 17 үүрэг даалгавар өгч, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр ТУЗ-ийг хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн, хорооны эрх үүргийг хэрэгжүүлсэн.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь банкны залгамж халааны бодлогыг тодорхойлох, банкны Хяналтын зөвлөлийн гишүүн, эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх, банкны эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлагын талаар дүгнэлт гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан, хараат бус байдлыг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх болон хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох, чөлөөлөх зэрэг асуудлаар мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд Нэр дэвшүүлэх хороо нийт 7 удаа хуралдаж, 16 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэр гаргалтад шаардлагатай санал дүгнэлт, мэдээллээр ТУЗ-ийг ханган ажилласан.

Цалин урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь банкны алсын хараа, онцлогт тохирсон, шударга ил тод, зах зээлд өрсөлдөхүйц нөхцөлийг хангасан, ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, банкны ашиг болон ажлын гүйцэтгэлд суурилсан ажилтны нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн цалин урамшууллын бодлогыг тодорхойлоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Цалин урамшууллын хороо 2025 онд нэг удаа хуралдаж холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж хорооны эрх, үүргийг хэрэгжүүлэв.



СТРАТЕГИИ



ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

Бид дунд хугацаандаа тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааг хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн, жижиг дунд бизнесийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, олон улсын жишигт нийцсэн санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэгч Үндэсний тэргүүлэгч банк байх зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

2025-2027 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:



1. Зах зээлээ тэлж, санхүүгийн үзүүлэлтүүдийг зорилтот түвшинд хүргэх, тогтвортой ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх
2. Тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэх
3. Цахим шилжилт хийж, дижитал сувгийг нэмэгдүүлэх
4. Харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
5. Банкны тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтууд:



- Ногоон банк – Тогтвортой хөгжлийн урт хугацааны стратеги-2030 хэрэгжүүлэх, тайлагнах
- Тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон болон нийгмийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, нэвтрүүлэх
- Тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн чиглэлээр санхүүгийн боловсрол олгох, зөвлөгөө мэдээлэл хүргэх
- Банкны үйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хийг цэвэр тэг /net zero/-д хүргэхэд зорьж ажиллах

Банк эдгээр зорилтуудын хүрээнд 2025 онд **“Тогтвортой хөгжлийн зорилтууд”** болон **“Тогтвортой хөгжлийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөө”** зэрэг баримт бичгүүдийг батлан, улирал бүр хэрэгжилтийг Тогтвортой хөгжлийн хороонд тайлагнан ажиллалаа.



УУР АМЬСГАЛЫН СТРАТЕГИ

Банк уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл, боломжийг тодорхойлон, бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг стратегийн түвшинд үнэлж байна. Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг биет эрсдэл болон шилжилтийн эрсдэл гэж ангилан авч үздэг.

Уур амьсгалын эрсдэл нь банканд шууд болон шууд бус байдлаар санхүүгийн нөлөөлөл үзүүлдэг. Энэхүү нөлөөлөл нь зээлдэгчид, хөрөнгө оруулагчид, харилцагчид болон макро эдийн засгийн орчноор дамжин банкны санхүүгийн үзүүлэлт болон эрсдэлийн түвшинд нөлөөлөх боломжтой.



Уур амьсгалын эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох

Шилжилтийн эрсдэлийн хүчин зүйлс

Бодлого, хуулийн Технологийн Зах зээлийн Нэр хүндийн

- ▶ ХХЯ-ын үнэ ихсэх
- ▶ Тайлангналын шаардлага нэмэгдэх
- ▶ Одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэмэлтээр хууль зохицуулалтын шаардлага тогтоох
- ▶ ХХЯ-аас ангижрах болсон эрчим хүчний шилжилтийн төлөвлөгөө
- ▶ Бага ялгарал бүхий технологид шилжих өртөг
- ▶ Одоогийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ бага ХХЯ-тай хувилбараар солих
- ▶ Харилцагчийн сэтгэлзүйн өөрчлөлт
- ▶ Зах зээлийн тодорхойгүй байдал
- ▶ Түүхий эд материалын өртөг, нийлүүлэлт
- ▶ Орлогч талуудын санаа зовох, хөрөнгө оруулагчдын сөрөг сэтгэгдэл нэмэгдэх

Биет эрсдэлийн хүчин зүйлс

Цочмог биет эрсдэл Ужиг биет эрсдэл

- ▶ Хотын үер
- ▶ Голын үер
- ▶ Хөрсний гулгалт
- ▶ Хээрийн түймэр
- ▶ Шуурга (салхин, элсэн)
- ▶ Зуд
- ▶ Аянга цахилгаан
- ▶ Мөндөр
- ▶ Температурын өөрчлөлт
- ▶ Хэт халалт
- ▶ Ган гачиг
- ▶ Усны хомсдол
- ▶ Хур тунадас ихсэх
- ▶ Цөлжилт
- ▶ Мөнх, цэвдгийн тархалт, газрын өөрчлөлт

Уур амьсгалын эрсдэлийн дамжих сувгийн үнэлгээ

Банк уур амьсгалын эрсдэлт хүчин зүйлсийг биет болон шилжилтийн эрсдэлээр ангилж, санхүүгийн үзүүлэлт болон уламжлалт эрсдэлийн ангилалд хэрхэн нөлөөлж болохыг үнэлэх зорилгоор таван үндсэн дамжих сувгийг тодорхойлсон. Үүнд:

Уламжлалт эрсдэл	Уур амьсгалын эрсдэлт хүчин зүйлс	Дамжих суваг	Хамаарах санхүүгийн үзүүлэлтүүд	Цаг хугацаа*	Уламжлалт эрсдэл	Уур амьсгалын эрсдэлт хүчин зүйлс	Дамжих суваг	Хамаарах санхүүгийн үзүүлэлтүүд	Цаг хугацаа*
Зээлийн эрсдэл	Шилжилтийн эрсдэл • ХХЯ-ын үнэ ихсэх • ХХЯ-аас ангижрах болон эрчим хүчний шилжилтийн төлөвлөгөө - Одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэмэлтээр хууль зохицуулалтын шаардлага тогтоох - Түүхий эд материалын өртөг, нийлүүлэлт - Харилцагчийн сэтгэлзүйн өөрчлөлт - Одоогийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ бага ХХЯ-тай хувилбараар солих - Бага ялгарал бүхий технологид шилжих өртөг	Бизнесийн тасалдал	- Зээлдэгчид санхүүгийн хариуцлагаа үүрэхгүйгээс шалтгаалсан хохирол - Санхүүгийн тогтворгүй байдал, уур амьсгалын нөлөөллөөс үүдэн зээлжих зэрэглэлд өөрчлөлт оруулах - Зээлийн үнэ цэнийн бууралт, барьцаа хөрөнгийн үнэлгээний бууралт - Хөрөнгийг данснаас хасах, актлах - Санхүүгийн тогтворгүй байдал	Дунд, урт	Хууль эрхзүйн	Шилжилтийн эрсдэл - Хуулийн хариуцлага хүлээх - Одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэмэлтээр хууль зохицуулалтын шаардлага тогтоох	Хуулийн шинэ зохицуулалтад нийцэхгүй байх	- Хуулийн хариуцлага хүлээхтэй холбоотой зардал ихсэх	Дунд, урт
Зах зээлийн эрсдэл	Биет эрсдэл	Зах зээлийн нөхцөл байдал	- Хөрөнгийн үнэ цэнэ өөрчлөгдөх - Нийлүүлэлтийн гинжин хэлхээн дэх барааны үнэ хэлбэлзэх	Дунд, урт	Зээлийн	Биет эрсдэл - Цочмог эрсдэл - Хур тунадас ихсэх - Температурын өөрчлөлт Цочмог эрсдэл: - Зуд - Мөндөр Ужиг эрсдэл: - Ган гачиг - Цөлжилт - Усны хомсдол	Бизнесийн тасалдал	-Зээлдэгчид санхүүгийн хариуцлагаа үүрэхгүйгээс шалтгаалсан хохирол учрах -Зээлийн үнэ цэнэ буурах, барьцаа хөрөнгийн үнэлгээ буурах	Дунд, урт
							Хөдөө аж ахуйн үржил шим гарц өөрчлөгдөх	- Макро эдийн засгийн сөрөг өөрчлөлтөөс шалтгаалсан хүлээгдэж буй зээлийн алдагдал ихсэх	Дунд, урт (зуд усны хомсдол) Урт, дунд, богино (ган гачиг, мөндөр, цөлжилт)

Уламжлалт эрсдэл	Уур амьсгалын эрсдэлт хүчин зүйлс	Дамжих суваг	Хамаарах санхүүгийн үзүүлэлтүүд	Цаг хугацаа*	Уламжлалт эрсдэл	Уур амьсгалын эрсдэлт хүчин зүйлс	Дамжих суваг	Хамаарах санхүүгийн үзүүлэлтүүд	Цаг хугацаа*
Зах зээлийн	Шилжилтийн эрсдэл • Зах зээлийн тодорхойгүй байдал - ХХЯ-аас ангижрах болон эрчим хүчний шилжилтийн төлөвлөгөө	Зах зээлийн нөхцөл байдал	- Орлого буурах, хөрөнгөө дахин үнэлэх - Хөрөнгө данснаас хасах, актлах - Зах зээлийн үнийн сөрөг өөрчлөлтөөс үүдсэн алдагдал - Зах зээл хэлбэлзэх	Урт	Үйл ажиллагааны	Биет эрсдэл • Хотын үер - Хээрийн түймэр - Мөнх цэвдгийн тархалт, газар өөрчлөгдөх - Хур тунадас ихсэх	Бизнесийн тасалдал	- Хөрөнгийн үнэ цэнэ алдагдах (хөрөнгө, тоног төхөөрөмж) - Капитал болон үйл ажиллагааны зардал (даатгал, засвар үйлчилгээ г.м.) ихсэх	Урт, дунд, богино
Үйл ажиллагааны	Шилжилтийн эрсдэл - ХХЯ-аас ангижрах болон эрчим хүчний шилжилтийн төлөвлөгөө - Бага ялгарал бүхий технологид шилжих өртөг - Тайлагналын шаардлага нэмэгдэх	Бизнесийн тасалдал	- Үйл ажиллагааны зардал нэмэгдэх - Богино хугацаат түргэн хөрвөх хөрөнгийг бууруулах - Шинэ журам нэвтрүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны өртөг зардал ихсэх - Үр бүтээмж буурах	Дунд, урт	Хөрвөх чадварын	Шилжилтийн эрсдэл - Харилцагчийн сэтгэлзүйн өөрчлөлт	Харилцагчийн сэтгэлзүйн өөрчлөлтөд хариу үзүүлж чадахгүй байх	- Санхүүжилтийн эх үүсвэр багасгах - Зээлийн шугамаас ашиглах - Санхүүжүүлэх өртөг ихсэх - Харилцагчид нэг дор хадгаламжаа авах	Дунд, урт

*Хугацааны хүрээ: богино (0-1 жил), дунд (1-3 жил), урт (>3 жил)

● Уур амьсгалтай холбоотой боломжууд

Уур амьсгалын өөрчлөлт нь нийгэм, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ дэлхийн эдийн засаг болон зах зээлийн орчинд томоохон өөрчлөлт авчирч байна. Энэ нь тодорхойгүй байдал, эрсдэлийг нэмэгдүүлж байгаа хэдий ч нөгөө талаас шинэ бизнесийн боломжийг бий болгож байна.

Банк уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг шинэ бизнесийн боломж болгон ашиглаж, урт хугацаанд тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна.


Уур амьсгалын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх үйл явцын хүрээнд Банканд хамаарах дараах үндсэн боломжуудыг тодорхойлсон. Үүнд:

- Банкны дотоод үйл ажиллагаанд нөөцийн үр ашиг болон эрчим хүчний хэмнэлтийг сайжруулах,
- Ногоон төсөл, байгаль орчинд ээлтэй бизнесүүдийг санхүүжүүлэх замаар зах зээлийн шинэ сегмент бий болгох,
- Ногоон болон тогтвортой санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх,
- Уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицол болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр санхүүгийн шийдэл санал болгох.


Банк нь орон нутгийн харилцагчид, ялангуяа малчдад чиглэсэн өргөн сүлжээтэй тул энэ давуу талаа ашиглан Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тулгамдсан асуудлууд, тухайлбал бэлчээрийн доройтол болон уур амьсгалын эрсдэлд өртөмтгий мал аж ахуйн салбарын тогтвортой байдлыг дэмжихэд хувь нэмэр оруулах боломжтой.



БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БҮТЭЦ



Тогтвортой хөгжлийн хороо

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны эрхлэх асуудлын хүрээнд банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах асуудал ордог.

Мөн Тогтвортой хөгжлийн хороо, түүний дэргэд Тогтвортой хөгжлийн албаны үйл ажиллагааг өргөжүүллээ. Гүйцэтгэх удирдлагын түвшинд Тогтвортой хөгжил хариуцсан Дэд захирлын ажлын байрыг шинээр бий болгож, Тогтвортой хөгжлийн албыг шууд удирдлагаар ханган ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн хороог Гүйцэтгэх захирал томилох бөгөөд тус хороо нь банкны тогтвортой хөгжлийн зорилтууд, хийгдэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийг тухай бүр хянах, бодлогын баримт бичгүүдийг батлах болон бусад асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт 12 удаа хуралдаж, чиг үүргийн хүрээнд тогтвортой хөгжлийн чиглэлээр 33 асуудлыг хэлэлцэж 37 шийдвэр гаргасан.

Тогтвортой хөгжлийн албаны чиг үүрэг

“Тогтвортой хөгжлийн алба”-ыг 2023 онд Банкны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд байгуулж, орон тоог нэмэгдүүлсэн.

Тогтвортой хөгжлийн алба нь ногоон банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэх, байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр стратеги, бодлогыг тодорхойлох, ногоон төсөл, хөтөлбөрүүдийг холбогдох төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, үүнд шаардлагатай эх үүсвэрийг татах, төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Түүнчлэн, тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, олон улсад нэгдэн орсон гэрээ, конвенц, стандартын дагуу үйл ажиллагаа явуулах, хүлэмжийн хийн ялгаруулалт болон уур амьсгалын эрсдэлийг тооцож, тайлагнах, бууруулах зэрэг ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.

Тогтвортой хөгжлийн алба нь Тогтвортой хөгжлийн хорооны үйл ажиллагааг хариуцан, хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн Тогтвортой хөгжлийн зорилт, төлөвлөгөөний хэрэгжилтэд анхан шатны хяналт тавьж, банкны хэмжээнд газар, хэлтсүүдийг нэгдсэн бодлого, чиглэл, арга зүйгээр ханган ажилладаг.

Банк 2025 онд Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийг татан буулгаж, тогтвортой хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлуудыг холбогдох газар, хэлтэс, албадын чиг үүрэгт болон ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод системтэйгээр тусгах ажлыг зохион байгууллаа. Ингэснээр тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг байгууллагын засаглал, өдөр тутмын үйл ажиллагаанд бүрэн нэгтгэх нөхцөлийг бүрдүүлэв.


УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл болон боломжийг хянах, стратегийн түвшинд удирдлагаар хангах үүргийг хэрэгжүүлдэг. Уур амьсгалтай холбоотой асуудлыг Банкны урт хугацааны стратеги, тогтвортой хөгжлийн зорилтууд болон нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд авч үздэг.

ТУЗ нь Банкны тогтвортой хөгжил болон уур амьсгалтай холбоотой бодлого, стратеги, бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, хэрэгжилтийн явцад хяналт

тавьдаг. Мөн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг Банкны Эрсдэлийн удирдлагын хороо болон Тогтвортой хөгжлийн хорооны хурлаар тогтмол хэлэлцүүлэн ажилладаг.

Банк 2025 онд IFRS S2 стандартын шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд уур амьсгалын эрсдэлийн удирдлагын суурь тогтолцоог бүрдүүлэх, 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталсан.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТҮҮХЭН ТОВЧОО

2014

ТоС Хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлж эхэлсэн.



2015

"Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, журам"-ыг анхлан батлууллаа.



2019

ТоС ажлын хэсгийг өргөжүүлэн шинэчлэн байгууллаа.



2022

"Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого"-ыг батлуулав.



2023

- 2-р сар Тогтвортой хөгжлийн албыг байгуулав.
- 3-р сар Банкны БОНЗ-ын бодлогод нийцүүлэн "Тогтвортой хөгжлийн журам"-ыг баталж, "Тогтвортой хөгжлийн хороо"-г байгууллаа.
- 5-р сар Нэгдсэн Үндэсний байгууллагын Даян дэлхийн гэрээн /UN Global Compact/-д оролцогчоор нэгдлээ.
- 6-р сар Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл /PCAF/-д гишүүнээр элсэн орлоо.



- 12-р сар Тогтвортой хөгжлийн жилийн тайланг анх удаа бэлтгэж олон нийтэд хүргэв.

2024

- 9-р сар Засгийн газраас Төрийн банкныг ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүрэгтэйгээр зохион байгуулав.
- 12-р сар Ногоон шилжилтийн реформыг хэрэгжүүлэх хүрээнд "Ногоон ирээдүй" бондыг биржийн бус зах зээлд гаргалаа.



2025

- 2-р сар "Тогтвортой санхүүжилтийн хүрээ"-нд S&P Global Ratings хөндлөнгийн үнэлгээ хийв.
- 4-р сар Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүжилтийн "WE Finance code"-д элслээ.
- 5-р сар Төрийн банкны Тогтвортой хөгжлийн зорилтуудыг батлав.
- 9-р сар Олон улсын зах зээлд 200 сая ам.долларын дүнтэй, 3 жилийн хугацаатай бондыг амжилттай гаргалаа.
- 10-р сар Уур амьсгалын эрсдэлийн зөвлөх үйлчилгээг авлаа.
- 11-р сар Хөдөлмөрийн харилцаа дахь хүний эрхийн эрсдэлийг илрүүлж, үнэлэх түргэвчилсэн шинжилгээ хийлгэв.
- 12-р сар "Тэрбум мод" сангийн "Шилдэг дэмжигч банк"-аар, Монголын Ногоон барилгын хүрээлэнгийн "Financial Solution" чиглэлийн манлайлагч байгууллагаар тус тус шалгарлаа.



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Бид Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогыг олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох баримт бичигт нийцүүлэн 2022 онд баталсан. Тус бодлогоор байгаль орчин, нийгэм, засаглалын талаар баримтлах зарчим болон зарчмын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон. Банк Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогын хэрэгжилтийг хангахад шаардлагатай холбогдох дотоод баримт, бичгүүд болон Тогтвортой хөгжлийн журам, Тогтвортой хөгжлийн хорооны үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, Хүлэмжийн хийн ялгарлыг тооцохтой холбоотой журам, зааврыг шинээр батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.



Байгаль орчны чиглэлд:

Хүлэмжийн хийн ялгарал болон уур амьсгалын сөрөг үр нөлөөнөөс үүсэх эрсдэлийг санхүүгийн хөшүүрэг ашиглан багасгах зорилтыг хэрэгжүүлэх



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Нийгмийн чиглэлд:

Байгаль орчны менежментийг хэрэгжүүлж буй харилцагчдад санхүүжилт олгох, дундаж давхаргын иргэдийн амьдралын чанарыг дэмжих зорилготой бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох



Засаглалын чиглэлд:

Банкны үйл ажиллагаа болон стратеги, бизнес төлөвлөгөөнд байгаль орчны асуудлыг авч үзэх, зохистой байдлын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох мэдээллийг ил тод тайлагнах

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН МАНЛАЙЛАЛ

Ногоон барилгын манлайлагч



Монголын ногоон барилгын хүрээлэнгээс ногоон барилгын **BestGER** шалгуурт нийцсэн барилга байгууламжийн тоог нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй барилгын дэвшилтэт технологийг нутагшуулах, олон нийтэд ногоон барилгын ач холбогдлыг сурталчлан таниулах чиглэлээр идэвх санаачилгатай ажилласан аж ахуйн нэгжүүдийг алдаршуулах зорилгоор **“Ногоон барилгын манлайлагч - 2025”** шагналыг Төрийн банканд гардууллаа.

Төрийн банк 2025 онд ногоон бэлтгэн нийлүүлэгчийн зээл болон ногоон орон сууцны зээлийг зах зээлд нэвтрүүлж, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны зээлийнхээ нэр төрлийг нэмэгдүүлсэн. Энэ нь ногоон барилгын салбарын хөгжилд томоохон дэмжлэг болж байгааг зохион байгуулагчид онцолж байв.

Тухайлбал, өнгөрсөн онд үндэсний ногоон барилгын үнэлгээний BestGER аргачлал батлагдсантай холбоотойгоор банкны зүгээс ногоон орон сууцны зээлийг зах зээлд нэвтрүүлж, зээлийн шалгууртаа тус үнэлгээг хийлгэх талаар тусгасан нь үнэлгээний систем практикт нэвтрэх, цаашлаад ногоон барилгын эрэлт өсөхөд томоохон түлхэц үзүүлсэн билээ.

Тэрбум мод сангийн шилдэг дэмжигч банк



Тэрбум мод сан нь Монголбанк, Монголын банкны холбооны гишүүн байгууллагуудын санаачилгаар 2022 онд байгуулагдсан бөгөөд банк санхүүгийн салбарынхан хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй санхүүжилтийн тогтвортой механизм бий болгох зорилгоор тус санг үүсгэн байгуулсан түүхтэй.

Банкны салбарын хамт олон Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөнийг дэмжин 50.0 сая мод тарих зорилт дэвшүүлж, энэ хүрээнд 1,435 га талбайд 3.53 сая мод тариад байна.

Төрийн банк нь Тэрбум мод сантай хэд хэдэн чиглэлээр хамтран ажиллаж, 232.6 мянган модыг Монгол орон даяар тарьж ургуулжээ. Мөн арчилгаа, хамгаалалтын ажлыг тогтмолжуулсны үр дүнд тарьсан моддын 90 гаруй хувь нь та бидэнд хүчилтөрөгч бэлэглэн ургасаар байна.

Төрийн банк нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллахын зэрэгцээ ажилтан нэг бүрийн идэвх оролцоогоор ногоон соёлыг түгээн дэлгэрүүлж, нийгэмд эерэг үлгэрлэл үзүүлэхийг ямагт зорин ажилладаг.

МАТЕРИАЛЛАГ СЭДВҮҮД

Төрийн банк олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран байгаль орчин, нийгэм засаглалын хүрээнд банкны материаллаг/чухал сэдвүүдийг тодорхойлсон билээ. Материаллаг/чухал сэдэв нь аливаа байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон урт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлс бөгөөд хөрөнгө оруулах, шийдвэр гаргахад тухайн хүчин зүйлсийг харгалзан үздэг. Төрийн банкны байгаль орчин, нийгэм, засаглалын материаллаг/чухал сэдвийг танилцуулбал:



Байгаль орчин

- Тогтвортой санхүүжилт
- Уур амьсгалын өөрчлөлт
- Нөөцийн зүй зохистой, хариуцлагатай хэрэглээ




Нийгэм

- Хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Харилцагчдын сэтгэл ханамж
- Компанийн нийгмийн хариуцлага
- Өртгийн сүлжээний удирдлага
- Инновац, судалгаа шинжилгээ болон хөгжүүлэлт
- Ажилтны оролцоо, хөгжил



Засаглал

- Бизнесийн ёс зүй
- Компанийн засаглал
- Кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал
- Эрсдэлийн удирдлага



Оролцогч талуудын санал, материаллаг сэдвийн хүрээнд замын зургийг боловсруулж, сайжруулах шаардлагатай ажлуудыг 2025-2027 онд хэрэгжүүлэх банкны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал:



Байгаль орчин

Банк нь тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийг дэмжсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх зорилтын хүрээнд “Ногоон бэлтгэн нийлүүлэгч”-ийн зээл, “Ногоон харилцах данс”-ны бүтээгдэхүүн, бэлтгэн нийлүүлэгчийн гэрээ байгуулсан байгууллагад зориулсан “Грийн КҮБ” үйлчилгээг, “Ногоон орон сууцны зээл” зэрэг бүтээгдэхүүнийг шинээр гаргалаа.

Мөн бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа байгаль орчинд ээлтэй байх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжилд чиглэсэн бизнесийн төслүүдийг санхүүжүүлэх зорилготой “Бизнесийн ногоон зээл”-ийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.

Банкны “Тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэх” стратегийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2025 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан “Уур амьсгалын эрсдэлийг тодорхойлоход шаардлагатай зөвлөх үйлчилгээг авах” ажлын хүрээнд “Эрнст энд Янг Монголия Аудит” компаниас уур амьсгалын эрсдэлийн удирдлага, хүлэмжийн хийн ялгаруулалт, СТОУС-ын тайлагнал, удирдлага болон мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт зохион байгуулах зэрэг таван үе шат бүхий “Уур амьсгалын эрсдэлийн зөвлөх үйлчилгээ”-г авлаа.

Тайлант онд цахим үйлчилгээний хэрэглээг өргөжүүлснээр цаасан суурьтай үйл ажиллагааг орлох боломж бүрдэж, байгалийн нөөцийн хэрэглээг бууруулахад бодитой хувь нэмэр оруулж, 918.1 тонн CO₂-ийн ялгаруулалтыг буурууллаа.

Нийгэм

Банкны ногоон зээлийн бүтээгдэхүүнийг сурталчлах, олон нийтэд тогтвортой хөгжлийн чиглэлээр мэдлэг олгох зорилгоор банкны албан ёсны цахим хуудсанд “Ногоон талбар” /<https://www.statebank.mn/greenloan/> цэсийг шинээр хөгжүүллээ.

Баримт бичгийг нээлттэй байлгах ажлын хүрээнд “Тогтвортой санхүүгийн хүрээ” болон “Ногоон таксономи”, “Тогтвортой хөгжлийн зорилтуудын таксономи” зэрэг баримт бичгийг банкны цахим хуудсанд нээлттэй байршууллаа.

Хөдөлмөрийн харилцаа дахь хүний эрхийн эрсдэлийг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ”-г Прайсютэрхаус Күүпэрс Легал ХХН (PWC) байгууллагаар хийлгэлээ.

Мөн “Монголын байгалийн өв сан”-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу “Шилжилтийн малчны цахим ногоон зээлийн бүтээгдэхүүн”-ийг туршин хамтран ажиллаж байна.

Засаглал

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа, арга зүйг “Эрсдэлийн менежментийн тогтолцоо MNS ISO 31000:2020 олон улсын стандарт”-д нийцүүлэн сайжруулах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүллээ.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



Төрийн банкны “Эрсдэлийн удирдлагын бодлого” нь банкны үйл ажиллагаанд учирсан болон учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, хянах замаар банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах, ашиг сонирхлын зөрчлөөс хараат бус байж эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгож хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Тайлант онд бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д Комплайнсын эрсдэлийн удирдлага, Тогтвортой байдал, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын талаар бүлэг нэмж, “Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

“Банкны нэгдсэн эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн аппетитыг тооцох аргачлал”-ын дагуу улирал бүр зээлийн эрсдэл, зах зээл, хөрвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, мэдээллийн технологийн эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл болон комплайнсын эрсдэлд үнэлгээ хийж, нэгдсэн эрсдэлийн үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд тогтмол тайлагнаж байна. Банкны стратеги төлөвлөгөө болон бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангахад банкны үйл ажиллагааны учирч болзошгүй эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, чанаргүй активыг төлүүлэх замаар банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлж, дэмжиж ажиллав.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Банк зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах, зээлийн үйл ажиллагаа болон зээлийн багцын чанарыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажилласан.

Тайлант онд банкны зээлийн багцын өсөлттэй уялдуулан зээлийн үйлчилгээг эрсдэл багатай зээлийн багцад байршуулах бодлого баримталж, чанаргүй активыг бууруулах дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажилласан. Үүний үр дүнд чанаргүй активын үлдэгдэл болон эрсдэлийн санг Төрийн банкны Зээлийн бодлого болон Эрсдэлийн удирдлагын бодлогод заасан зохистой түвшинд удирдаж, зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан.

Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор Төрийн банкны 2025 оны “Эрсдэлийн аппетит”-ийг баталж, Гүйцэтгэх захирлын тушаалаар 2025 оны “Эрсдэлийн аппетитын мэдэгдэл”-ийг батлан мөрдүүлж, тогтоосон хязгаар, шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг тогтмол хянаж, банкны удирдлагууд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд тайлагнаж ажилласан.

Зээлийн үйл ажиллагаанд ашиглаж буй систем, программ хангамжийн хөгжүүлэлтийг тайлант онд үргэлжлүүлэн гүйцэтгэж, нэмэлт сайжруулалтуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Зээлийн хүсэлтийг хүлээн авч судлахаас эхлэн зээл төлөгдөж дуусах хүртэлх үйл ажиллагааг цогц байдлаар зохицуулах “Зээлийн нэгдсэн программ”-ын тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор программын код, дизайн, үндсэн шийдэлд сайжруулалт хийж, бүх төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг судлах боломжийг бүрдүүлсэн. Скорингийн болон рейтингийн үнэлгээний шинэ аргачлалыг “Зээлийн нэгдсэн программ”-д бүрэн интеграцчилж, хэрэглээний болон бизнесийн зээлийн судалгааг нэгдсэн сууриар гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ. Ингэснээр зээлийн

- судалгааны хугацааг багасган, шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлэв.
- Банк Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС-9)-ыг хэрэгжүүлэх, тайлагнах ажлын хүрээнд активын хүлээгдэж буй алдагдлын (ECL) тооцооллын программын параметр болон өгөгдлийн сангийн интеграцчиллыг сайжруулж, тайлагналын процессыг боловсронгуй болгосон. Активын хүлээгдэж буй алдагдлын хэмжээг сар бүр тус программаар тооцож гарсан үр дүнд дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн Монголбанканд СТОУС-9 стандартаар зээлийн тайланг тогтмол тайлагнаж байна.
- Зээлийн судалгаанд ашиглах зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний түүхэн дата бүрдүүлэх, зээлийн барьцаа хөрөнгийг богино хугацаанд олон улсын үнэлгээний стандартад нийцүүлэн үнэн зөв үнэлэх, тайлагнах, хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор банкны зээлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн “Хөрөнгийн үнэлгээний программ”-ын дата санг өргөтгөж, тайлагнал болон хяналтын модулийг сайжруулсан. Ингэснээр барьцаа хөрөнгийн үнэлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломж нэмэгдэж, үнэлгээний ил тод байдал, хяналтын үр нөлөө сайжирсан.



ЗАХ ЗЭЭЛ, ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛ

- Банк нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хүүгийн эрсдэл, гадаад валютын ханшийн эрсдэл зэрэг гадаад орчноос хамаарсан эрсдэлүүдээс шалтгаалан банкны эзэмшиж буй санхүүгийн хэрэгсэлийн өнөөгийн үнэ цэн, ирээдүйд үүсэж болзошгүй алдагдлыг VaR аргачлалаар тооцоолж, эрсдэлийг удирдаж тайлант хугацаанд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцаа үзүүлэлт болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан 2025 оны Эрсдэлийн аппетит, Эрсдэлийн аппетитын мэдэгдлийг бүрэн хангаж ажиллалаа.
- Банкны зах зээл эзлэлт, бизнесийн загвар, бизнес төлөвлөгөө болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд учирч болзошгүй эрсдэлийг зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу Өөрийн хөрөнгийн хүрэлцээг үнэлэх аргачлал(ICAAP), Хөрвөх чадварын эрсдэлийг үнэлэх аргачлал (ILAAP)-ын хүрээнд тодорхойлж, дотоодод мөрдөж буй зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн хязгаар үзүүлэлтийг шинэчлэн тогтоож, тогтмол хяналт тавьж ажилласан.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

- Банк үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ ТУЗ-өөс баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн аппетитын хүрээнд банкны стратеги, бизнес төлөвлөгөөний зорилтуудад нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэл бууруулах төлөвлөгөөг баталж, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.
- Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа, арга зүйг “Эрсдэлийн менежментийн тогтцолцоо MNS ISO 31000:2020 олон улсын стандарт”-д нийцүүлэн сайжруулж үйл ажиллагаанд нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүллээ.
- Эрсдэл ба хяналтын үнэлгээний аргачлал (RCSA)-ын дагуу банкны газар, хэлтэс, алба, бизнес нэгжид эрсдэлийн үнэлгээ болон хэсэгчилсэн үнэлгээг улирал бүр хийж, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж эрсдэл бууруулах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.
- Банк 2025 онд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг сайжруулах зорилгоор Дотоод ашиглан, залилангийн эрсдэлийн удирдлага, Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөө, түүний үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилласнаас гадна эрсдэлийн соёлыг бэхжүүлэх чиглэлээр ажилтнуудад тогтмол сургалт явуулж, холбогдох заавар зөвлөмжийг өгч ажиллалаа.
- Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөний дагуу сургалт, дадлага, туршилт хийх ажлуудыг үе шаттай хэрэгжүүлж ажиллалаа.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЭРСДЭЛ

- Мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцүүлэн шаардлагатай технологийн шинэчлэлт, процессын сайжруулалтыг хийж ажиллалаа.
- Төрийн банкны харилцагчийн мэдээллийн нууцлал болон аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь олон улсын түвшинд хэрэгжиж байгааг мэдээллийн аюулгүй байдлын олон улсын ISO/IEC27001:2022 стандарт болон төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCI-DSS стандартын аудитаар баталгаажууллаа.



КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛ

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан “Комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ” аргачлалын дагуу “Хуулийн этгээд, өмчийн хэлбэр”, “Ёс зүйн эрсдэл”, “Нэр хүндийн эрсдэл”, “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэл”, “Үйл ажиллагааны эрсдэл” гэсэн 5 төрлөөр тус үнэлгээнүүдийг хийхэд Төрийн банкны комплайнсын эрсдэл нь “Бага” түвшинтэй үнэлэгдлээ.
- Компанийн зохистой засаглалыг хэрэгжүүлж ёс зүй, ил тод байдал, хариуцлага болон шударга байдлыг мөрдөх зорилгоор Шүгэл үлээх бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл баталлаа.
- Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор сэжигтэй гүйлгээ илрүүлэх тусгай хяналтын системд Solaris -AI Machine learning программыг амжилттай нэвтрүүлээ.



УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛ

Банкны “Тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэх” стратегийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2025 оны бизнес төлөвлөгөөнд уур амьсгалын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах тогтолцоог бий болгох зорилтыг тусгасан.

Энэ хүрээнд Банк уур амьсгалын эрсдэлийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх зорилгоор олон улсын туршлагатай зөвлөх байгууллагатай хамтран ажилласан. Уур амьсгалын эрсдэлийн зөвлөх үйлчилгээний хүрээнд 2025 онд дараах үндсэн ажлуудыг хэрэгжүүлэв. Үүнд:

- Уур амьсгалын эрсдэлийг банкны одоогийн эрсдэлийн удирдлага болон засаглалын тогтолцоонд үе шаттайгаар нэвтрүүлэх зөвлөмж боловсруулав.
- IFRS S2 стандартын шаардлагад нийцүүлэх хүрээнд холбогдох бодлого, журмын баримт бичгийг сайжруулах санал боловсруулсан.
- Уур амьсгалын эрсдэлийн сценарь шинжилгээ хийж, Банканд нөлөөлөх боломжтой гол эрсдэл болон боломжийг тодорхойлов.
- Сценарь шинжилгээнд ашиглах ерөнхий аргачлал болон Excel-д суурилсан хэрэглүүр боловсрууллаа.
- Банкны хамрах хүрээ 1 болон 2-ын хүлэмжийн хийн ялгаруулалтад үндэслэн бууруулах зорилт тодорхойлох зөвлөмж боловсруулав,
- Санхүүжилтийн стратегийг уур амьсгалын зорилттой уялдуулах чанарын зөвлөмж боловсруулсан.
- IFRS-д нийцсэн уур амьсгалын тайлагналын загвар боловсрууллаа,
- Банкны ажилтнуудад зориулсан сургалт, воркшоп зохион байгуулж дотоод чадавхыг бэхжүүлэв.




Энэхүү хамтын ажиллагааны үр дүнд Банк уур амьсгалын эрсдэлийн удирдлагын суурь тогтолцоог бүрдүүлж, IFRS S2 стандартын шаардлагад нийцсэн тайлагналын бэлтгэлийг хангах, цаашид хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг батлах нөхцөлийг бүрдүүлсэн.

СЦЕНАРЬ ШИНЖИЛГЭЭ

Монголбанк Нэгдсэн Үндэсний Байгууллагын дэргэдэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн түншлэл (NDC Partnership)-ийн дэмжлэгтэйгээр “Төв банкныг ногоон болгоход бэлэн байдлын дэмжлэг үзүүлэх” төслийг 2023 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн зөвлөх багаар НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP) ажиллаж байна. Энэхүү төслийн хүрээнд банкны салбарын уур амьсгалын стресс тестийг туршилтаар гүйцэтгэхээр төлөвлөж, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл (ган, зуд, үер зэрэг биет эрсдэл болон Парисын хэлэлцээрийн зорилттой холбоотой шилжилтийн эрсдэл) нь банкны зээлийн эрсдэлд хэрхэн нөлөөлөхийг үнэлэх аргачлал, судалгааны баримт бичигт үндэслэн уур амьсгалын өөрчлөлтийн сценарь шинжилгээг боловсруулсан.

Мөн зөвлөх үйлчилгээний байгууллагын Хонгконг дахь тогтвортой байдлын зөвлөхүүд банкны уур амьсгалын эрсдэлийн сценарь шинжилгээг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн.



Сценарь шинжилгээг Санхүүгийн байгууллагыг ногоон болгох сүлжээ (NGFS)-ийн уур амьсгалын сценариудад тулгуурлан гүйцэтгэсэн. NGFS-ийн сценариуд нь уур амьсгалын бодлого, зохицуулалт, технологийн хөгжил болон эдийн засгийн өөрчлөлтөөс шалтгаалан биет болон шилжилтийн эрсдэл хэрхэн өөрчлөгдөхийг харуулдаг. Шинжилгээнд дараах гурван сценарь ашигласан. Үүнд:

- 1. Одоогийн бодлого (Current Policies)** – Одоо хэрэгжиж буй бодлогууд хэвээр үргэлжилнэ гэж үзэх бөгөөд урт хугацаанд шилжилтийн эрсдэл өндөр байх нөхцөлийг илэрхийлнэ.
- 2. 2°C-ээс доош (Below 2°C)** – Уур амьсгалын бодлого аажмаар чангарах замаар дэлхийн дулаарлыг 2°C-ээс доош барих боломжтой сценарь.
- 3. Хойшлогдсон шилжилт (Delayed Transition)** – 2030 он хүртэл ялгаруулалт буурахгүй бөгөөд дараа нь дэлхийн дулаарлыг хязгаарлахын тулд илүү хатуу бодлого хэрэгжүүлэх шаардлагатай нөхцөлийг илэрхийлнэ.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Банк анх удаа Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхэлсэн.

Сценарь шинжилгээний ажлын урсгалын диаграм



Уур амьсгалын сценарь шинжилгээ нь банкуудыг уур амьсгалтай холбоотой тодорхой бус байдлаа олж мэдэхэд нь туслах алсыг харсан ойлголтоор хангаж, эрсдэл, стратеги, хөрөнгө төлөвлөлтийн талаар мэдээлэлтэй байж шийдвэр гаргах боломжийг олгодог.

1 Стратегийн зээлийн удирдлага

- Уур амьсгалд өртөмтгий салбар болон зээлдэгчдийг тодорхойлох
- Капиталаа уур амьсгалд тэсвэртэй, бага хүлэмжийн хий ялгаруулдаг (ХХЯ) салбаруудаас эхэлж хуваарилах
- Нүүрстөрөгчгүйжүүлэлт болон хүлэмжийн хийн тэнцвэртэй уялдах урт хугацааны стратеги бодлогыг дэмжих

2 Зээлийн эрсдэлийн үнэлгээг сайжруулах

- Уур амьсгалын PD, LGD, ECL-ийг олон сценариар тооцох
- Зээлдэгчийн биет болон шилжилтийн эрсдэлийг зээлийн андеррайтингд нэгтгэх
- Уур амьсгалын эмзэг байдалд суурилан барьцаа хөрөнгийн үнэлгээ болон зээлийн үндсэн нөхцөлийг тохируулах

3 Капитал төлөвлөлт болон эрсдэлийн удирдлага

- Уур амьсгалын эрсдэлийг тодорхойлох, бууруулах ЗГ-ын шийдвэрийг дэмжин ажиллах
- Уур амьсгалын стресстэй нөхцөлд эрсдэлээр жигнэсэн актив (RWA), өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR)-д үзүүлэх нөлөөг үнэлэх
- Уур амьсгалын эрсдэлийн босгыг тодорхойлж, эрсдэлийн аппетитийн үнэлгээнд оруулж өгөх.

4 Засаглал болон оролцогч талуудын оролцоо

- Сценарт суурилсан ойлголтоор дамжуулан удирдах зөвлөлийн түвшний хяналтыг сайжруулах
- TCFD-тэй уялдсан тоон сценарийн үр дүн бүхий тайлагнал гаргах, сайжруулах
- Зохицуулагч байгууллага, хөрөнгө оруулагчдад уур амьсгалын эрсдэлийг урьдчилан удирдах буйгаа харуулах.


**ХАМТЫН
АЖИЛЛАГАА,
ТҮНШЛЭЛ**



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тайлант онд гадаад зах зээлд бонд гаргах ажлын хүрээнд MUFG банктай хамтран боловсруулсан Тогтвортой санхүүжилтийн хүрээ /Sustainable Finance Framework/-г Хонгконгийн "S&P Global Ratings" байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ /SPO/-г амжилттай хийлгэж хүлээн авлаа. Хөндлөнгийн байгууллагын үнэлгээгээр Төрийн банкны Тогтвортой санхүүжилтийн хүрээ нь олон улсын ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой хөгжилтэй уялдсан бондын зарчим болон ногоон зээл, нийгмийн зээлийн зарчмуудтай нийцсэн, "сул тал илрээгүй" гэж дүгнэгдсэн.

Төрийн банкнаас олон улсын зах зээлд 200 сая ам.долларын дүнтэй, 3 жилийн хугацаатай бондыг амжилттай гаргаж, бондын төлбөр тооцоо хийгдэх журмын дагуу бондын хэлцлээр босгосон эх үүсвэрийг тайлант хугацаанд хүлээн авлаа.



Америкийн Нэгдсэн Улсын "Cargill Financial Services International" байгууллагаас Хөдөө аж ахуйг дэмжих зориулалттай 45.0 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлээ.



Дэлхийн банкнаас Төрийн банктай техник тусалцааны чиглэлээр хамтран ажиллах шийдвэр гарч, Төрийн банканд зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, ногоон шилжилтийн хүрээнд техник тусалцаа үзүүлэхээр ажиллаж байна.



Гадаад хамтын ажиллагаа, корреспондент харилцааг өргөжүүлэх хүрээнд АНУ-ын "Bank of New York Mellon" банктай Хамтран ажиллах гэрээ (Global Banking Agreement)-г байгуулан, тус банктай SWIFT RMA түлхүүр солилцсон ба 2026 оны эхэнд ам.долларын ностро данс нээгдэх эхлэлийг тавилаа.



Монгол улсын зээлжих зэрэглэл сайжирсантай холбогдуулан Moody's байгууллагаас Төрийн банкны зээлжих зэрэглэлийг шинэчлэн тогтоож, хэтийн төлөв "Тогтвортой", зээлжих чадамжийн үнэлгээ "B1" болгон ахиулж, баталгаажуулав.



Банкны бэлэн валютын нөөцийг хангах зорилгоор Хонгконгийн "Moneycorp" байгууллагатай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд бэлэн валютын зузаатгал авч эхэлсэн.



Төрийн банкны олон улсын төлбөр тооцооны систем нь Swift Alliance cloud орчин руу бүрэн шилжлээ. SWIFT системийн "SWIFT essentials" багцын "GPI tracker" үйлчилгээг банкны үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлсэн

ГИШҮҮНЧЛЭЛ

НҮБ-ын Даян дэлхийн гэрээ



НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (UN Global Compact) -ний оролцогчоор 2023 онд нэгдсэнээс хойш бид бодлого, шийдвэр гаргалтдаа байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын зарчмуудыг нэвтрүүлж, тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцсэн үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлж байна. Энэхүү оролцооны хүрээнд бид 2025 онд хоёр дахь удаа явцын тайлан буюу “Communication on Progress” тайланг албан ёсоор хүргүүлсэн бөгөөд цаашид жил бүр амлалтаа бататган, хэрэгжилтийн ахиц дэвшлийг тогтмол тайлагнахаар зорьж байна. Мөн ажилтнууд, харилцагчид, хөрөнгө оруулагчид, түнш байгууллагууд болон бусад оролцогч талтай харилцан итгэлцэл, урт хугацааны хамтын ажиллагааг бэхжүүлж байна.

Банк ирэх онд Хамтын түншлэл бүхий харилцагч нартаа НҮБ-ын Даян дэлхийн гэрээний 10 зарчмын хүрээнд сургалт орох, зөвлөгөө, мэдээллийг цахимаар тогтмол хүргэн ажиллахаар төлөвлөж байна.

Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл



Төрийн банк нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхийн хамтын ажиллагааг дэмжин, үйл ажиллагаагаа Парисын хэлэлцээр болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд банк хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын эрсдэлийг санхүүжилтийн шийдвэрт тусгах, байгаль орчинд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Банк нь 2023 оны 6 дугаар сард Нидерланд Улсын санаачилсан Partnership for Carbon Accounting Financials (PCAF)-д Монгол Улсаас тав дахь гишүүн байгууллагаар нэгдсэн. Энэхүү санаачилгын хүрээнд банк зээл болон хөрөнгө оруулалтын багцтай холбоотой хүлэмжийн хийн ялгарлыг олон улсын нэгдсэн аргачлалын хүрээнд ажилтнуудаа сургаж чадавхижуулан, холбогдох дотоодын баримт бичгийг боловсруулан, программын бэлтгэл ажлыг хангаснаар 2026 оноос эхлэн ил тод тайлагнах зорилт тавин ажиллаж байна. Энэ нь банкны санхүүжилтийн үйл ажиллагааг уур амьсгалын зорилттой нийцүүлэх, тогтвортой санхүүжилтийг бэхжүүлэхэд чухал алхам болж байна.



Төрийн банк нь Монголбанк, Монголын банкуудын холбоо, санхүүгийн зохицуулах хороо, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Монгол Улсын их хурлын оролцоотой “Women Entrepreneurship Finance Code” буюу “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код” санаачилгад нэгдэн орлоо.

Тус санаачилгад нэгдсэнээр түншүүд болон бусад сонирхогч талуудтай хамтран манлайлал үзүүлэх, өгөгдлийг сайжруулах, эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан хязгаарлалт, санхүүжилтийн дутагдлыг арилгахад туслах арга хэмжээ авах бөгөөд эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнесийг дэмжих санаачилгыг манлайлах, эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнесүүдийн санхүүжилтийн түвшинг хэмжих

зорилгоор холбогдох үзүүлэлтийг хэмжиж, хянах, мөн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих арга хэмжээг өргөжүүлэн ажиллах амлалтыг өглөө.

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэхээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг авч байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөрийн тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн тэргүүлэх зорилтуудын хүрээнд төрийн санхүүжилтийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний бодлоготой уялдуулах, байгальд ээлтэй, ногоон төсөл хөтөлбөрийг дэмжих, төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллаж байна.

Тухайлбал, тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрчим хүчний яам болон Зээлийн батлан даалтын сантай дараах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүллээ.



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ



ЭРЧИМ
ХҮЧНИЙ ЯАМ



“Ди би эм ассет
менежмент” ХХК



ЗЭЭЛИЙН БАТЛАН
ДААЛТЫН САН

■ **Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам**, Амины орон сууц, инновац хөгжлийн төв ТББ болон олон улсад сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр болон ногоон эрчим хүч, цахилгаан машин, ухаалаг утас, өндөр хурдны 5G сүлжээний технологиор дэлхийд түүчээлж буй Хуавей Технологи ХХК-тай хамтран өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 69 бэлтгэн нийлүүлэгч оролцсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгч, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд оролцон инновацлаг шийдэл бүхий байгаль орчинд ээлтэй, ногоон технологид суурилсан эрчим хүчний хэмнэлттэй агаар, хөрсний бохирдлыг бууруулах олон шийдлийг агуулсан бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулан борлуулалтыг хийлээ. Арга хэмжээний үеэр банк харилцагчид үзүүлэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж 300.0 сая төгрөг хүртэл ногоон зээлийн хүсэлтийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэн ажилласан. Тус өдөрлөгийг зохион байгуулснаар хэвлэл мэдээллийн байгууллага, сошиал сувгаар “Ногоон хөгжлийг дэмжигч Төрийн банк” үзэл баримтлал, оролцогч талуудын ногоон технологийн мэдлэг, мэдээллийг давхардсан тоогоор 8.0 сая иргэдэд хүргэж ажиллалаа.



■ “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-НОГООН БАРИЛГА” сэдвийн хүрээнд салбарын экспертүүд, бодлого тодорхойлогчид болон санхүүгийн байгууллагуудыг оролцуулан дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлж, цаашид хэрэгжүүлэх ногоон төсөл хөтөлбөрүүд, ирээдүйн чиг хандлага болоод салбарын хөгжилд ямар боломж, шийдлүүд байгаа талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Банк нь Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам болон Ногоон барилгын хүрээлэн ТББ-ын арга зүйн дэмжлэгтэй ногоон барилгын үнэлгээ, хяналт, баталгаажуулалтын “BestGer” стандартыг үндэслэн ногоон барилгын зээлийн бүтээгдэхүүнийг шинээр хөгжүүлж, Ногоон орон сууцны зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.

■ **Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам**, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрчим хүчний яам, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулж буй “Дулаан байшин” өдөрлөгийн хүрээнд 4 өдрийн турш эрчим хүчний хэмнэлттэй амины ногоон орон сууц шинээр барих, засварлах, дулаалах, эрчим хүчний инновацлаг шийдлүүд бүхий ногоон зээлийн үйлчилгээг санал болгож, 800 гаруй харилцагчдад тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг хүргэн ажилласан.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 06-р сарын 20, 21-ний өдрүүдэд Төв аймгийн Зуунмод суманд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамнаас зохион

засгийн өсөлтийг дэмжихэд хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд тайлант хугацаанд банкны ажилтан болон банкны харилцагч нарт чиглэсэн Тогтвортой хөгжил, санхүүжилтийн талаарх мэдлэг мэдээллийг түгээн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газар болон Дэ Нэйче Консерванси (The Nature Conservancy)-Монгол дахь төлөөлөгчийн газар, байгаль хамгааллын байгууллагууд хамтран

■ **Монголын Байгалийн Өв Сан итгэлцлийн санг байгуулсан бөгөөд Төрийн банк нь** “Өнө мөнхийн Монгол” байгаль хамгаалах байнгын санхүүжилтийн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх, Тусгай хамгаалалттай газар нутаг болон орчны бүсэд Ногоон малчны зээл олгох туршилтын төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөн хамтран ажиллаж байна.

Банкны зүгээс төслийн ерөнхий загвар, малчны ногоон зээлийн шалгуур, олголт



байгуулагдсан “АЛТАН ХАЙЧ-2025” хонь ноослох улсын анхдугаар тэмцээнд Төрийн банк хамтран ажиллаж, иргэдэд банкны ногоон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн ажиллалаа.



Төрийн банкны тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Олон улсын болон дотоодын зах зээлээс бага хүүтэй, урт хугацаат ногоон санхүүгийн эх үүсвэрийг дамжуулан зээлдүүлэх, ногоон төслүүдийг бэлдэх, үр нөлөөг хэмжих, тайлагнах, баталгаажуулах чадавх, тогтолцоог бүрдүүлэхэд хамтран ажиллах, сургалт мэдлэгийг хуваалцах чиглэлд мэргэжлийн оролцогч байгуулагатай хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллахад онцгойлон анхааран, үйл ажиллагааг өргөжүүлж байна.

■ **Монголын Тогтвортой Санхүүжилтийн холбоо** ТББ-тай Монгол Улсын санхүүгийн салбар болон бизнесийн байгууллагуудад байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой санхүүжилт, ногоон зээл, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлж, тогтвортой хөгжил, ногоон эдийн

хийх үйл явцыг хялбарчлах, цахимаар олгох боломжийг бий болгох чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлж байна. Монголын ногоон санхүүгийн корпорацитай хамтын ажиллагааны хүрээнд Ногоон хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх оновчтой механизмыг хөгжүүлсний үндсэн дээр урт хугацаатай, бага хүүтэй бөөний зээлийг нэгдсэн стандартаар олгох, энэхүү үйл явцад Төрийн банкны оролцоог хангах чиглэлтэй байна.

■ **“Тэрбум мод”** сан байгуулагдсан цагаас эхлэн 4 жил гаруй хугацаанд банкуудын санхүүжилтээр нийт 93 төсөл хэрэгжүүлэн, 3,451,342 ширхэг модыг Монгол орны говь, хангайн бүсүүдэд нийтдээ 1,435 га газарт тарьж, 90 хувиас дээш ургалтын үр дүнтэйгээр ургуулан, арчилгаа хамгаалалтыг тогтмолжуулан, хяналт тавин ажиллаж байна.

Төрийн банк 2025 онд “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг дэмжих зорилгын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгальд ээлтэй, тогтвортой, ногоон хөгжлийг бий болгоход томоохон хувь нэрийг оруулж, нийт 232,587.7 ширхэг мод буюу нийт модны 6.74 хувьтай тэнцэх хэмжээний мод тарихад дэмжлэг үзүүлэн, 1,066.98 тн CO₂ хүлэмжийн хийг шингээж ажилласан байна. Банк “Тэрбум мод” сантай 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр “Хамтран ажиллах гэрээ”-г үзэглэж цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг өргөжүүлэн ажиллалаа.



- **Монголын бэлчээр судлалын ногоон алт төв нь** бэлчээрийн газрын менежмент, малчдын амьжиргааг дэмжих, өртгийн сүлжээг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийн шинэ технологийг нэвтрүүлэх, бэлчээрийн үндэсний хэмжээний мониторингийн сүлжээг бий болгох, хөгжүүлэх, сургах, бэлчээрийн зохистой дадлын стандартыг нэвтрүүлэх чиглэлээр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг. Эрүүл бэлчээр, тогтвортой, хариуцлагатай мал аж ахуйгаар дамжуулан Монгол болон дэлхий дахинд экологийн тэнцвэр, биологийн олон янз байдлын хамгаалал болон тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулсан ирээдүйг бүтээх зорилготойгоор хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, бодлогын түвшинд хамтран ажиллаж байна.



- Уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, бохирдол ихтэй гэр хорооллыг орлогод нийцсэн, нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, амьдрах таатай орчин бүхий эко-хороолол болгон хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд нийцсэн хот байгуулалт болон орлогод нийцсэн ногоон орон сууцны санхүүжилтийн хооронд үүссэн зөрүүг арилгах зорилготой "Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахаар **"Ди Би Эм Ассет менежмент"** ХХК-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.




- Тогтвортой хөгжлийн үйл ажиллагаа, ногоон зээлийн бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах, сурталчлах, зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор "Гурван тулгуурт хөгжлийн гүүр" НҮТББ, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хүртээмж итгэл үндэсний зөвлөл" НҮТББ, "Вай Эс Вай Вүүд" ХХК, "Арвин алтан бумба" ХХК, "Гэрэлт өргөө хаус" ХХК болон "Хангал констракшн" ХХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.



ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ - ХАМТЫН ТҮНШЛЭЛ

- Төрийн бодлогын зохицуулалт, банкны салбарын санхүүжилтийн нөөц болон хувийн хэвшлийн инновацыг мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэгтгэх замаар Тогтвортой хөгжил зорилт, ногоон эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготой **“Тогтвортой өсөлт-хамтын түншлэл”** цогц нэтворкинг арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж байна.



Ногоон бизнесийг дэмжихэд зориулсан зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад санал болгох, бүтээгдэхүүний борлуулалтыг идэвхжүүлэх, зээлийн багцыг нэмэгдүүлэх зорилгоор банкттай хамтран ажилладаг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудыг хамруулан **“Тогтвортой өсөлт-хамтын түншлэл I”**



Монголын Ногоон барилгын хүрээлэн болон эрчим хүчний салбарт шинэ технологи нэвтрүүлэгч **“BIB Discovery Energy”** компанитай хамтран барилгын эко шийдлүүд санал болгогч 50 гаруй компанийн төлөөллийг хамруулан **“Тогтвортой өсөлт-хамтын түншлэл II”**,




Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ОЙН ГАЗАР



Тогтвортой хөгжлийн чиглэлээрх банкны бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор **“Тэрбум мод”** сантай хамтран, сангийн гишүүн байгууллагууд болон банкны ажилтнуудад зориулан **“Тогтвортой өсөлт-хамтын түншлэл III”**.



A hand is shown from the bottom left, holding a clear glass globe. A small, vibrant green tree with a thin trunk and a full canopy of leaves grows out of the top of the globe. The background is a soft, out-of-focus green, suggesting a natural, outdoor setting. The overall image conveys a message of environmental stewardship and sustainability.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТОГТВОРТОЙ АЖИЛ ЭРХЛЭЛТ



Тогтвортой ажлын байр:

Төрийн банк Монгол орон даяарх нийт аймаг хот, сум дүүргийн 3,300 гаруй ажилтныг ажлын байраар хангаж тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Нэгжийг үр ашигтай ажиллуулах бодлого баримтлан ажлын гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоонд шинэчлэл хийж, үр дүнд суурилсан өрсөлдөхүйц цалин хөлсний тогтолцоог бэхжүүлэв. Хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, инфляцын түвшин, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдуулж нийт ажилтны үндсэн цалинг дунджаар 6.4 хувиар нэмэгдүүллээ. Банкны ажилтнуудын ур чадварын үнэлгээг 2 удаа хийж, ажилтнуудын карьерын өсөлтийг дэмжсэнээр нийт ажилтны 11.1 хувь нь албан тушаал ахисан ба хүний нөөцийн гаралтын харьцааг 13.9 хувь буюу зохистой түвшинд барив.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй:

Төрийн банк нь Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO45001:2018 олон улсын стандартыг банк санхүүгийн салбарт анх удаа нэвтрүүлсэн нь ажилтны аюулгүй байдлыг олон улсын түвшинд баталгаажуулах томоохон алхам боллоо. Стандартын хэрэгжилтийг Францын Afnor Groupe болон Үндэсний итгэмжлэлийн төвд итгэмжлэгдсэн "Мон Сертф" ХХК давхар баталгаажуулсан амжилттай ажиллалаа.



АЖИЛТНЫ САЙН САЙХАН БАЙДАЛ

Төрийн банк ажилтны сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлдэг. "Байгууллагын дотоод соёл, бүтээмж, ажилтны сэтгэл ханамжийн судалгаа"-г 2 дахь жилдээ гадны байгууллагатай хамтран хийж, судалгаанд суурилсан зорилтот ажлуудыг хэрэгжүүлж байна.



Биеийн эрүүл мэнд:

- Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор улсын болон эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран, ажилтнуудыг сонгосон багцаар нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрууллаа.
- Ажилтнуудын бие бялдрын хөгжил, идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжиж "GYMHUB" төслийн багтай хамтын ажиллагааны хүрээнд нэг гишүүнчлэлийн бүртгэлээр хамтрагч 16 фитнес клуб, бялдаржуулах төвүүдээр өөрийн сонгосон цагт үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж 100 гаруй ажилтныг хамруулаад байна.
- "Бий биелгээ", "Zumba fitness" сургалт, "Хаврыг угтъя – 2025" витаминжуулалтын аян, "Дугуй унах – зөвхөн дасгал биш, дэлхийдээ илгээж буй хайр" уриалга, "Цусаа хандивлаж, амьдрал бэлэглэе" аяныг хэрэгжүүлж, эрдэс, аминдэмийн оношилгоо, зөвлөгөөнд хамруулав.



Сэтгэл зүйн эрүүл мэнд: "Happy Employee" сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр



"Эрүүл ажилтан – Эрүүл байгууллага" аян

эрүүл мэнд, стресс менежмент, зан үйл сэдэвт сургалт

150
ажилтан

Эрүүл мэнд ба зан үйл" сэдэвт сургалт

210
ажилтан



"Эрүүл ажилтан – Эрүүл байгууллага" аян

Сэтгэл зүйн эрүүл мэнд – Амьдралын чанар"

396
ажилтан

"Нойрны чанар ба ажил, амьдралын тэнцвэр" онлайн сургалт



"Удирдлагын манлайлал ба Удирдагчийн сэтгэл зүй"

сэдэвт сургалтад

удирдлагын багийг хамруулав.



Хамтын хуримтлалын хадгаламжийн хөтөлбөр:

Ажилтан сайн дураараа үндсэн цалингаас хуримтлал үүсгэж, хугацаанаас хамаараад хадгаламжийн үлдэгдлийн тодорхой хувиар тэтгэмж авах нөхцөл бүхий "Хамтын хуримтлалын хадгаламж"-ийг хэрэгжүүлж байна.



Баг, хамт олны оролцоо

Банк нь ажилтны оролцоог дэмжиж, багийн үйл ажиллагаа, соёлын арга хэмжээ тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Баг хамт олны идэвхжүүлэлт, хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлага, байгууллагын соёлыг төлөвшүүлэх **"Талархлын өдрүүд"** аян болон **"Манлайлагч хамт олон-2025"** уралдааныг уламжлал болгов.



"Ажилтнаа сонсьё"

өдөрлөг зохион байгуулж хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, ажилтнуудтай санал солилцлоо.

"Just in time" хөтөлбөр Ажилтнуудын цагийн менежмент, хувийн зохион байгуулалтын судалгаа хийж, хойргошил / procrastination /-той тэмцэх арга зам, үр дүнтэй цагийн менежментийн арга зүйд сургах, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэв.

Ногоон оффис-Байгальд ээлтэй Төрийн банк хөтөлбөрийн хүрээнд **"Ногоон оффис зохистой дадал-2025"** аяны батлагдсан удирдамжийн дагуу ногоон оффисын гарын авлагыг ажилтан бүрд таниулах, ногоон зээлийн бүтээгдэхүүн борлуулах, ажлын байраа тохижуулах ажлыг зохион байгуулж амжилттай оролцсон 5 нэгжийг урамшууллаа.



Ажил-амьдралын тэнцвэр:

- Ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хангах замаар ажилтны идэвх оролцоо, байгууллага хамт олны үнэ цэнийг нэмэгдүүлж, аз жаргалтай гэр бүлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх "Гэр бүлд ээлтэй банк" хөтөлбөрийг хэрэгжүүллээ.
- Ажилтнуудад ажилтны хүүхдийн тоогоор сургалт хөгжлийн үйл ажиллагаатай танилцах цалинтай чөлөө, төрсөн өдрийн чөлөөг жилд нэг удаа, хөгжлийн бэрхшээлтэй ажилтан болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй ажилтанд улирал бүр, шууд удирдлагын болон хуримын, ар гэрт гачигдал гарсан зэрэг тохиолдлуудад тухай бүр цалинтай чөлөө олгодог.
- Банкны төвийн газар, хэлтэс, албадын зайнаас ажиллах боломжтой албан тушаалыг шинэчлэн, ажлын цагийн хуваарийг уян хатан байлгах зохицуулалт хэрэгжүүлснээр банкны төвийн ажилтнуудын 50 хувь нь уян хатан сонголтоор ажиллаж байна. Ингэснээр ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хадгалахад дэмжлэг үзүүлэв.
- Чингэлтэй дүүргийн 39 дүгээр цэцэрлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, банкны ажилтнуудын 2-5 насны 20 орчим хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулсан.



ХҮНИЙ ЭРХ, ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ

Банк нь шийдвэр гаргалт болон үйл ажиллагааны бүхий л түвшинд хүний эрхийг хүндэтгэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахыг нийт ажилтнуудад уриалан, хандлагыг өөрчлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлсээр ирлээ.

Хүний эрхийн магадлан шинжилгээ:



Банкны хөдөлмөрийн харилцаанд “Хөдөлмөрийн харилцаа дахь хүний эрхийн эрсдэлийг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ”-г Прайсуотэрхаус Күүпэрс Легал ХХН (PWC) байгууллагаар гүйцэтгүүлсэн.

Энэхүү шинжилгээгээр Банкны хөдөлмөрийн

харилцаан дахь хүний эрхийн нөхцөл байдалд нөлөөлж буй бодит болон болзошгүй эрсдэлийг НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн Удирдах зарчимтай нийцүүлэн тодорхойлж, Банкны оролцооны байдлыг үнэлж, эрэмбэлсэн ерөнхий зөвлөмж өгч, зөвлөмжийн мөрөөр холбогдох эрх зүйн баримт бичгийг шинэчлэн сайжруулж, авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж байна.



Хөдөлмөрийн маргаан таслах комисс:

Банкны “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, түүнийг байгуулах, маргааныг шийдвэрлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу хөдөлмөрийн маргаан таслах комисс байгуулагдаж, 2025 онд 4 удаа хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргасан. Маргаан таслах комиссоор ажилтны гомдлыг хэлэлцсэнээр гомдлыг шүүхэд шилжихээс шийдвэрлэх, цаг хугацаа хэмнэх, санхүүгийн болон сэтгэл зүйн хохирол үүсэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.



Ажилтны баримтлах ёс зүйн хэм, хэмжээ:

Ажилтны ёс зүйн дүрэмд ёс зүйн 8 зарчим, зарчмын хүрээнд баримтлах 4 ёс зүйн нийтлэг хэм хэмжээг шинэчлэн тодорхойлноос гадна эрх бүхий албан тушаалтан, удирдах албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг шинээр нэмж “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг шинэчиллээ. Дүрэмд ёс зүйн зөрчил, зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, хэлэлцэх асуудлыг Ёс зүйн зөвлөл, Шүгэл үлээх бодлогоор шийдвэрлэх зохицуулалтыг тусгаж эрх зүйн баримт бичгийн нийцлийг хангуулсан.


ЖЕНДЕР, ОЛОН ТАЛТ БАЙДАЛ

Ажлын байрны зарыг банкны вэб сайт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын хөдөлмөрийн биржийн сайтад нээлттэй байршуулж, шаардлага хангасан 82 иргэнийг ажлын байраар хангаж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах харилцаа”, “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” танхимын сургалтыг зохион байгуулж, “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сэдвийн хүрээнд видео хичээлийг шинээр бэлтгэн, Улаанбаатар хотын 81 нэгжийн мэдээллийн самбар, зурагтаар 2 минутын бичлэг байршуулж, харилцагчдад мэдээлэл түгээсэн.

Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэв.


- Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажлын байрны дарамт, хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэгдсэн сургалтанд 319 ажилтанг хамрууллаа.
- “Ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийллээс ангид байх, эрх, тэдгээрийн шинж илрэл” сургалтад УБ хотын нэгжийн 70 удирдах ажилтныг хамруулав.
- “Жендэрийн эрх тэгш байдал” сэдэв сургалтад 766 ажилтан хамрагдсан. Бүтээгдэхүүн, үйлчилгээ болон жендэрийн эрх тэгш байдалд чиглэсэн сургалтуудыг шинэ ажилтны сургалтын хөтөлбөрт тусгаж, 16 удаагийн сургалтад 244 ажилтныг хамрууллаа.



СУРГАЛТ, ХӨГЖИЛ



Банкны стратеги, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар бүхий хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх замаар банкны ашигт ажиллагаа, ажилтан болон харилцагчийн сэтгэл ханамж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн 7096 цагийн сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж, 156 удаагийн сургалтад давтагдсан тоогоор 12,047 ажилтныг хамруулав.



Сургалтын багц цагийн хөтөлбөр нэвтрүүлэв. Сургалтын багц цагийн систем нь Шинэ ажилтан, Нэгжийн ажилтан, Банкны төвийн ажилтан, Удирдах ажилтан, Сургагч багшийн багц цаг гэсэн үндсэн 5 нэгж сургалтын хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд Банкны ажилтны заавал эзэмших ур чадваруудыг тодорхойлсон. Хөтөлбөрийн хүрээнд 12 кредит, 96 цагийн хөтөлбөрт 3925 ажилтныг хамруулав.

“Сайн туршлага -2025” хөтөлбөр



Банканд үр бүтээлтэй ажилласан ажилтнуудаас сонгож подкаст ярилцлага, Story Telling, workshop хэлбэрээр видео контент бүтээж, цахим хэлбэрээр нийт ажилтанд түгээсэн.

Тогтвортой хөгжлийн чиглэлээр:



Нийт 21 удаагийн 4720 цагийн сургалтад 1452 ажилтныг хамруулж, тогтвортой хөгжлийн 20 бүлэг сэдвээр видео сургалт бэлтгэсэн.

“Women in Finance” хөтөлбөр



ToC Холбоо, Азийн Сангийн хамтарсан Австралийн Засгийн Газрын дэмжлэгтэй санхүүгийн салбарын эмэгтэйчүүдийн манлайллын “Women in Finance” хөтөлбөрт Төрийн банкны төлөөлөл оролцов.

Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр:

Их, дээд сургуулийн оюутан залууст практикт суурилсан ажлын бодит туршлага хуримтлуулах, ажлын гарааны суурийг цогцоор нь зөв эхлүүлэх боломжийг олгож байна. Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн хамтран ажиллах гэрээ бүхий их сургуулиудын III-IV түвшний оюутнууд болох Мандах их сургууль-10, ХААИС-70, ИЗОУИС-11, нийт V түвшний 91 оюутныг цалинтай










дадлагдажүүлсан ба шинээр МУИС, ОУЭЗБИС-тай хөтөлбөрийн дээрх хүрээнд хамтран ажиллах санамж бичиг байгуулав. Өмнө жилүүдэд хөтөлбөрт хамрагдсан оюутнуудаас тус онд 14 оюутан нэгжийн теллер албан тушаалд үндсэн ажилтнаар томилогдон ажиллаж байна.

ЦАХИМ ШИЛЖИЛТ



Бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг дэмжих хүрээнд Гялсбанк үйлчилгээнд нэмэлт сайжруулалт, хөгжүүлэлт хийснээс гадна өөрөө үйлчлэх (self-service) сувгийг өргөтгөж, бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэн үндсэн орчинд бүрэн нэвтрүүлээ.

Гялсбанк 3.0



-  Хувийн санхүү модуль сайжруулалт,
-  Харилцагч хоорондоо нэхэмжлэх үүсгэх, төлөх,
-  Шүүхийн шийдвэрийн ерөнхий газрын нэхэмжлэл төлөх,
-  E-Mongolia ашиглан харилцагч өөрийн мэдээллээ шинэчлэх,
-  Картаа и-баримтад автоматаар бүртгүүлэх
-  Картыг нэг удаагийн кодоор идэвхжүүлэх, шуудангийн системтэй интеграц хийж хүргэлтийг автоматжуулах




Цахим бүтээгдэхүүн

-  Цахимаар олгож буй зээлийн гэрээг тоон гарын үсгээр баталгаажуулан 7 төрлийн цахим зээлийг харилцагчдадаа олгож байна. Цахим зээлийг 100 хувь автоматаар шийдвэрлэж, харилцагчдад 24/7 зарчмаар зээл авах боломжийг бүрдүүлэв.
-  Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчдад банкны үйлчилгээг хялбараар хүргэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох бүтээгдэхүүн, үйлчилгээг валютын сонголттой нээх боломжтой боллоо.
-  Үндэсний соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах зорилгоор Юнионпэй “Splendor plus” картыг гаргах бэлтгэл ажлыг хангалаа.
-  Гялсбанк үйлчилгээнд “Мод тарих” цэс буюу “Гялс төгөл” нэртэй цэсийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлэв.

Тогтвортой хөгжил

-  Хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцооллын программ нэвтрүүлж тооцоолол, тайлагнал хийх боломжийг бий болголоо.
-  Банкны ногоон зээлийн бүтээгдэхүүнийг сурталчлах, олон нийтэд тогтвортой хөгжлийн чиглэлээр мэдлэг олгох зорилгоор банкны албан ёсны цахим хуудсанд “Ногоон талбар”
/https://www.statebank.mn/greenloan/ цэсийг шинээр хөгжүүлээ.





НОГООН ОФФИС

Байгууллагын соёлдоо ногоон орчныг нэвтрүүлэх, эрчим хүч, ус, цаас зэрэг нөөцийг зохистой ашиглах, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, хэмнэх зэрэг дадлыг ажилтнууддаа хэвшүүлэх зорилготой “Ногоон оффисын заавар”-ыг мөрдөж байна.



Хэрэгжүүлсэн ажлууд

Ажлын байранд тогтвортой хөгжлийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх, ажилтнуудын байгаль орчинд ээлтэй хандлага болон хариуцлагатай хэрэглээг дэмжих зорилгоор нийт ажилтнуудын дунд “Ногоон оффис – Зохистой дадал” аяныг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.



Худалдан авах ажиллагаанд ногоон шалгуурыг тусгаж хэрэгжүүлж байна



Банкны хэрэглээнд 10 цахилгаан автомашин худалдан авч, бензин, дизель зэрэг түлшний хэрэглээг 6 хувиар буурууллаа.



Хүлэмжийн хийг бууруулах зорилгоор ажилтнуудад зориулсан нийтийн тээврийн хэрэгслийг ашиглаж байна.



Ажилтнуудаа зайнаас ажиллах нөхцөлийг бүрэн бүрдүүлэн ажиллаж байна.



Банкны төв оффист эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмжүүдийг суурилууллаа.



Хуванцар болон төмрийн хаягдлыг тушааж, модны хаягдлыг түлээ, түлш шаардлагатай ажилтнуудад хандивлан хог хаягдлыг буурууллаа.



210 кг хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Банк нь өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2022 оноос эхлэн тооцож, эхний жилд хэмжилтийг мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн. Харин 2023 оноос дотоод чадавхдаа тулгуурлан, олон улсын болон үндэсний аргачлалуудыг хослуулан ашиглаж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бие даан тооцож байна. Тухайлбал, ISO 14064-1:2018 стандарт, Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл /PCAF/ байгууллагын Санхүүжүүлсэн ялгаруулалт тооцох стандарт, Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан “Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргачлал”-ыг ашигласан.

2025 оны байдлаарх банкны хүлэмжийн хийн ялгаруулалтын бүтэц дараах байдалтай байна:



Хамрах хүрээ 1 (Score 1): 881.0 тонн CO₂e

Хамрах хүрээ 2 (Score 2): 6,811.1 тонн CO₂e

Хамрах хүрээ 3 (Score 3): 151,175.9 тонн CO₂e



Хөрөнгө оруулалт, зээл,
санхүүжилт:
135,601.0 тонн CO₂e



Ажилтнуудын зорчих
хөдөлгөөн болон томилолт:
706.7 тонн CO₂e




Худалдан авалт
болон хог хаягдал:
7,176.1 тонн CO₂e




Санхүүжүүлсэн ялгаруулалт

- Санхүүжүүлсэн ялгаруулалтын (Score 3) тооцооллыг гүйцэтгэхдээ 2025 оны зээл, хөрөнгө оруулалтын багцад хамаарах, зориулалт нь тодорхой зээл, санхүүжилтийг PCAF-ийн стандартад нийцүүлэн хамруулан тооцсон.



Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах арга хэмжээ

- Банк нь 2025 онд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах чиглэлд үйл ажиллагааны болон менежментийн шийдлүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж, нийт 946.15 тонн CO₂-ийн ялгаруулалтыг бууруулсан үр дүнд хүрсэн. Хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь ялгаруулалтыг бууруулахаас гадна нөөцийн үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх, ажилтнуудын оролцоог дэмжих, тогтвортой хөгжлийн соёлыг байгууллагын түвшинд төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой байв. Үүнд:



Дээрх арга хэмжээнүүд нь банкны үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмыг системтэй нэвтрүүлэх, цаашид хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах урт хугацааны суурийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Хүлэмжийн хийн шингээлт

- Банк нь байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулах зорилгоор **“Модыг Мод(а) болгоё – Ажилтан бүр нэг мод”** дотоод аяныг тогтмол хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд банкны ажилтнууд идэвхтэй оролцож, мод тарих, арчлах үйл ажиллагааг өргөжүүлснээр нийт тарьж ургуулсан модны тоо өссөн байна. Үүний зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд банк идэвхтэй нэгдэж, “Тэрбум мод сан”-тай хамтран ажиллаж байна. Уг хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй ойжуулалт, нөхөн сэргээлтийн төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр мод тарих ажлыг нэмэгдүүлэх, экосистемийг сэргээхэд бодит хувь нэмэр оруулж байна.



Дээрх санаачилгуудын үр дүнд банкны ажилтнуудын тарьж ургуулсан мод болон сангийн хүрээнд хэрэгжсэн төслүүдээс бүрдэх нийт нөлөөллийг нэгтгэн тооцоход тайлант хугацаанд 1,200.2 тонн CO₂-ийн хүлэмжийн хийг шингээсэн үзүүлэлттэй байна.



ХУДАЛДАН АВАЛТЫН БОДЛОГО

“Төрийн банкны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам”-д ногоон шалгуурыг тусгаснаар 2025 оны нийт худалдан авалтын 39%-д ногоон шалгуур үзүүлэлт бүхий худалдан авалт хийгдсэн байна.



Түүнчлэн тайлант хугацаанд нийт худалдан авалтын **97.5%** -д дотоодын байгууллага, иргэнээс худалдан авалт хийсэн.



Банкны хэрэгцээнд
10 цахилгаан автомашин
худалдан авсан.



Бараа бүтээгдэхүүний нийт **58**
худалдан авалтад **A+** эрчим хүчний
хэмнэлттэй, дахин боловсруулсан
түүхий эдээр хийсэн байх шалгуур
үзүүлэлтийг тусгаж худалдан авсан



Барилга угсралтын **5**, нийт **27** ажлын
барилга засварын **22** хүрээнд

хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг
нөлөөгүй, стандартын шаардлага хангасан
барилгын материал буюу ногоон худалдан
авалтын шалгуурыг тусган зохион байгуулсан.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Тайлант онд 1800-1881 тусгай дугаарт хандсан харилцагчийн нийт асуудлын 98.5 хувийг эхний хандалтаар шийдвэрлэсэн ба 1.5 хувийн санал, хүсэлт, гомдлыг бүртгэн, холбогдох газар, хэлтэс, алба, салбар, нэгжид илгээж 99.6 хувийг хугацаанд нь шийдвэрлүүлсэн.



Харилцагч 1800-1881 тусгай дугаарт хандаж үйлчилгээ авсны дараа сэтгэл ханамжийн үнэлгээ өгдөг болсон ба 90.7 хувь нь маш сайн, хангалттай гэж үнэлгээг өгсөн байна.

Тайлант хугацаанд


Нийт гүйлгээнд цахим
гүйлгээний эзлэх хувь

91%



ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Харилцагчийн өдөрлөг арга хэмжээг 21 аймаг 330 сум, есөн дүүрэгт уламжлал болгон зохион байгуулж байна.



- Өмнөговь-Гурвантэс,
- Дундговь-Эрдэнэдалай сум,
- Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт

“Эрүүл амьдралын жигүүр” ТББ-тай хамтран амжилттай зохион байгууллаа.

10,905
харилцагчид



Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөө өгч

3,048
харилцагчид



- ▶ “Санхүүгийн боловсрол”,
- ▶ “Тогтвортой хөгжил-Ногоон санхүүжилт”,
- ▶ “Эрүүл мэндийн боловсрол” олгох биечилсэн сургалтыг хүргэсэн.



Эрүүл иргэн багц бүтээгдэхүүн нээлгэсэн

189 харилцагчийг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамруулсан.



“Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ-2025” аяныг 2025 оны тавдугаар сарын 17-ны өдөр орон даяар өрнүүлж Улаанбаатар хотын есөн дүүрэг, 21 аймаг, 330 сумын нутаг дэвсгэрт байрлах гол горхи, нуур цөөрмийн эрэг, усны сав газар, ойн нөөц

бүхий газруудад цэвэрлэгээ хийв. Нийт 8,000 гаруй га талбайгаас 1,000 орчим тонн хог хаягдал цуглуулж, хогийн цэгт төвлөрүүлсэн.




Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Хүүхдийн ордонд зохион байгуулагдсан “BECAUSE I AM A GIRL” 1000 охидын чуулганд санхүүгийн боловсрол олгох

зөвлөгөө мэдээлэл өгөх, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах, оролцогчдын дунд идэвхжүүлэх ажлыг зохион байгуулав.



Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран харилцагчдадаа цаг агаарын болзошгүй аюул, гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гялсбанк аппликейшн”-ий “МЭДЭГДЭЛ” цэсээр 42 удаа сэрэмжлүүлэх мэдээлэл хүргэсэн.



Хог хаягдлын менежмент гэсэн хэсгийг “ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ”-ийн чиглэлээр олон нийтэд мэдээлэл өгөх, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5 цуврал контент

бэлтгэн банкны албан ёсны социал сувгуудаар дамжуулан харилцагч олон нийтэд хүргэсэн



Төрийн банк нь тогтвортой хөгжил, ногоон өсөлтийг түүчээлэгч системийн нөлөө бүхий банкны хувьд, дотоод болон гадаад орчинд чиглэсэн авлигын эсрэг арга хэмжээг үйл ажиллагаандаа шат дараатай тусган хэрэгжүүлдэг.



Авлигатай тэмцэх газартай хамтран Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй хэн бүхэнд “ҮГҮЙ” гэж хэлээд өөрчилье уриан дор “Авлигын эсрэг нэгдье” аянд нэгдэн ажилтнууд болон харилцагч олон нийтэд мэдээлэл уриалга гаргасан.



Төрийн банк ногоон хөгжлийг дэмжигч банк болсонтой холбогдуулан “Миний Монгол-2025” үзэсгэлэн худалдааг “Тогтвортой хөгжилд хамтдаа” уриан дор “Аури Крейтив” ХХК-тай хамтран МҮЭСТО-нд 2025 оны хоёрдугаар сарын 17-ны өдрөөс хоёрдугаар сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. Үзэсгэлэнд нийт 81 бүүт байршуулан 117 бизнес эрхлэгчдийг хамруулснаас 39 бизнес эрхлэгч нь Төрийн банкны харилцагч байснаас гадна, 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг оролцуулжээ. Нийт 10 мянга гаруй иргэн тус үзэсгэлэн худалдаанд хүрэлцэн ирсэн.



Төрийн банкны нийт ажилтнуудын дунд “Модыг Мод(а) болгоё - ажилтан бүр нэг мод” аяныг бүх нийтийн хавар болон намрын мод тарилтын өдрүүдийг тохиолдуулан 2025 оны тавдугаар сард болон аравдугаар сард тус тус амжилттай зохион байгууллаа. Тус аяны хүрээнд Төрийн банкны газар, хэлтэс, алба, салбар, нэгжүүд нь тус бүр дотооддоо зохион байгуулалт хийж ногоон төгөл, төвлөрсөн байршил, цэцэрлэгт хүрээлэн болон өөрсдийн эзэмшлийн хашаандаа нийт 34 нэр төрлийн 4,772 мод тарьсан.


Ногоон зээл тогтвортой хөдөө аж ахуйн зээлийн бүтээгдэхүүнийг зорилтот хэрэглэгчид хүртээмжтэй, үр дүнтэй хүргэх зорилгоор Шинэчилгээ ТББ -тай “Малчдын моод” контент болон Эн Эн Си Си ХХК-тай “0.07 ургуулах моод” контентын хүрээнд хамтран ажиллалаа.



Түүнчлэн “Шинэчилгээ” ТББ-аас санаачлан хэрэгжүүлсэн Ургуулах Моод, Малчдын Моод төслийн хүрээнд Дархан-Уул аймагт хийгдсэн зурагт авалтын үеэр “Эхлэл” хүүхдийн хадгаламжийг сурталчлав.



“Жайка” төслөөс зохион байгуулсан танилцуулах өдөрлөгийн явуулын банкаар ажиллаж банкны бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулав. Тус үйл ажиллагаанд топ 5 банкууд болон 100 гаруй аж ахуй нэгж оролцсон.



Зэрлэг ан амьтныг хамгаалах зорилгоор Хүрээлэн төсөлтэй хамтран ажиллаж “Эко карт”-ыг зах зээлд нэвтрүүлэн картын борлуулалт тус бүрээс 2,000 төгрөгийг тус санд төвлөрүүлэв.



Европын Холбооны “Свич-Эйшиа” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Эдийн засгийн ногоон шилжилт” төслийн хүрээнд зохион байгуулагдсан TEDxUlaanbaatar - The Greeners арга хэмжээний үеэр

“Тогтвортой дадал, үйлдвэрлэлийг дэмжих зах зээлийн хөшүүрэг” сэдэвт панел хэлэлцүүлэгт оролцлоо. Хэлэлцүүлгээр дамжуулан ногоон банкны үйл ажиллагаа болон банкны ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулав.

Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тус байгууллагаас ирүүлсэн **“Монгол орны бэлчээрийн Үндэсний форум VIII”**-д банкны Өвөрхангай аймаг салбарын төлөөлөл оролцлоо.



“Тогтвортой хөгжил, ногоон ирээдүй” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.



Чингэлтэй дүүргээс зохион байгуулсан **“Дулаан гэр-Цэвэр агаар 2025”** арга хэмжээнд банк ногоон санхүүжилтийн мэдээлэл өгч, ногоон зээлийн бүтээгдэхүүний борлуулалт хийв. Тус арга хэмжээ нь хүйтний улирлаас урьтаж, гэр

байшингаа дулаалах бүх төрлийн барилгын эко дулаалгын материалуудын шийдэл, мэргэжлийн зөвлөгөө, ногоон технологийн шийдлүүдийг нэг дороос авах боломжийг бүрдүүлсэн юм.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



Банкны Инкубатор төв болон хамтран ажиллагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа, санхүүгээ амжилттай удирдахад шаардлагатай мэдлэг олгох, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийт 12,668 бизнес эрхлэгчдэд танхимын болон онлайн сургалтыг зохион байгууллаа. Сургалтын сэдвүүдэд энтрепренершип ба инновац, дизайн сэтгэлгээ, стратегийн удирдлага, байгууллагын хөгжил, үйл ажиллагаа, санхүү, маркетинг, эрсдэлийн удирдлага болон гарааны бизнесийн эрхзүй зэрэг багтжээ.



“САНХҮҮЧ ТАГТАА” ХӨТӨЛБӨР

Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд, багачууд, залуусын санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, ирээдүйн банкны харилцагч дундаж давхаргыг бэлтгэх, хуримтлал бий болгох дадал зуршил олгох зорилгоор “Санхүүч

тагтаа” хөтөлбөрийг боловсруулсан. Хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн суралцагчдад зориулан Улаанбаатар болон орон нутгийн бүх салбар, тооцооны төвөөр дамжуулан хэрэгжүүлж, 71,469 оюутан, сурагчийг сургалтанд хамруулсан.



“ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ 2025” ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨР

Сургалт судалгааны Полиси төвтэй хамтран Бизнесийн стратеги төлөвлөлт, Тогтвортой хөгжил ба ногоон маркетинг, Санхүүгийн удирдлага ба процессын үр ашгийг нэмэгдүүлэх, Хүний нөөцийн менежмент сэдвийн хүрээнд 1 сарын цогц сургалт зохион байгууллаа.



“ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ 2025”

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан төслийн хүрээнд 3 хөтөлбөр, 4 чуулга уулзалт зохион байгуулав.



“МАНЛАЙЛАЛД СУУРИЛСАН БИЗНЕСИЙН СТРАТЕГИ БА ӨСӨЛТ”

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан бойжуулах хөтөлбөрийг МУИС-ийн Шинжлэх ухаан технологийн Улаанбаатар паркттай хамтран хэрэгжүүлэв. Энэ хүрээнд стратеги төлөвлөлт, борлуулалтын стратеги,

санхүүгийн удирдлага, байгууллагын менежмент, дижитал шилжилт, социал маркетинг, манлайлал, оюуны өмчийн талаар цогц мэдлэг олгож, шинэ мэдлэг, туршлагаа байгууллагын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх 4 долоо хоногийн цогц сургалтыг хийж, нийт 35 оролцогчид сертификат гардууллаа.



“БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ”

“Тасралтгүй мөрөөдье, тасралтгүй нөлөөлье, тасралтгүй хөгжье” уриан дор Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг МУИС-ийн Шинжлэх ухаан технологийн Улаанбаатар паркттай хамтран зохион байгуулж 100 гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хамрагдав.



“БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ”

“Сэтгэлгээгээ өөрчил, бизнесээ хөгжүүл” уриан дор орон нутгийн бичил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, инновац шингэсэн шинэ санаа, бизнесийг хөгжүүлэх, туршлага хуваалцах зорилго бүхий энэхүү чуулга уулзалтад Орхон аймгийн өрхийн болон гарааны бизнес эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл болсон 150 гаруй бизнес эрхлэгч оролцлоо.



“ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ БА БҮТЭЭЛЧ БИЗНЕС” ОРХОН АЙМАГ

Бичил, жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулсан бойжуулах хөтөлбөрийг СЭЗИС-тай хамтран зохион байгууллаа. Хөтөлбөрт 42 бизнес эрхлэгч хамрагдаж, чуулга уулзалтын үеэр сертификат гардууллаа.



“БИЧИЛ ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ЧУУЛГА” УУЛЗАЛТ

“Сэтгэлгээгээ өөрчил, бизнесээ хөгжүүл” уриан дор орон нутгийн бичил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, инновац шингэсэн шинэ санаа, бизнесийг хөгжүүлэх, туршлага хуваалцах зорилго бүхий энэхүү чуулга

уулзалтад Орхон аймгийн өрхийн болон гарааны бизнес эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл болсон 150 гаруй бизнес эрхлэгч оролцлоо.



“МОНГОЛЫН ЭНТЕРПЕНЕРҮҮДИЙН НЭГДСЭН ЧУУЛГАН 2025”


МУИС-ийн харьяа Бизнес консалтинг төв нь Монголын Энтерпенүүдийн Нэгдсэн Чуулганыг 2014 оноос зохион байгуулж

байна. Энэхүү чуулган нь Монгол Улсад энтрепренершиппийг хөгжүүлэх, гарааны бизнес, энтрепренершиппийн таатай орчин-экоосистемийг бий болгох, иргэд, аж ахуйн нэгжүүдийн энтрепренерлэг сэтгэлгээ, урам зоригийг өдөөх, тухайн талбар дахь ололт, амжилтыг тэмдэглэхэд чиглэсэн энтрепренерийн чиглэлээрх хамгийн том арга хэмжээ юм.

Тус арга хэмжээг “Их сургууль, бизнесийн байгууллагын түншлэл” сэдвийн дор МУИС, МҮХАҮТ болон Төрийн банкны Инкубатор төв хамтран зохион байгууллаа.

“МИНИЙ МОНГОЛ” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА


Улаанбаатар хот болон орон нутгийн 21 аймагт бизнес эрхлэгчдийг дэмжих “Миний монгол” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.



Улаанбаатар хот болон орон нутгийн 21 аймагт бизнес эрхлэгчдийг дэмжих “Миний монгол” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд 2,205 харилцагч оролцоноос 847 инкубатор төвийн бойжигч, 22 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцож, бизнес эрхлэгч нар үзэсгэлэн худалдааны үеэр 1.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийлээ.

ЦАХИМ СУРГАЛТЫН ПЛАТФОРМ

Төрийн банкны www.statebank.ufe.mn цахим сургалтын платформоор дамжуулан бизнес эрхлэгчдэд бизнесийн удирдлага, санхүүгийн боловсрол олгох сургалтыг тогтмол хүргэж байна. Тус платформд бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 50 хувь нь худалдааны салбарт, 17 хувь нь үйлчилгээний салбарт, үлдсэн 33 хувь нь хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, барилга, эрүүл мэнд зэрэг бусад салбарт үйл ажиллагаа явуулж байна.



2025 оны 10 дугаар сараас эхлэн сургалтын платформд цахим сертификатыг нэвтрүүлснээр 600 бизнес эрхлэгч амжилттай суралцаж, цахим сертификат гардан авсан байна.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ, ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ



Инкубатор төвийн харилцагч

40,533
бизнес эрхлэгч

247,967
оюутан сурагч

11,878
малчин иргэнд



санхүүгийн боловсрол,
зөвлөгөө, мэдээлэл
хүргэлээ.



Орон нутгийн малчин иргэнд тогтвортой ХАА, ногоон эдийн засаг болон санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг банкны дотоод сургалтын платформд байршуулж, орон нутгийн бүх аймаг, сумдын нэгжүүдээр дамжуулан 11,878 малчин иргэнд санхүүгийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.

Малчдын
САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ БА
ХАМТЫН ХҮЧ

- Малчдын Бизнесийн хөгжлийн чиг хандлага
- Мал аж ахуйн бизнесийн ялгарал
- Хоршоо ба тогтвортой хөгжил

Инкубатор төв нь зөвлөх үйлчилгээ, дэмжих үйлчилгээ, сургах, хөгжүүлэх үйлчилгээ, бизнесийн хурдасгуур хөтөлбөр, хамтын ажиллагаа зэрэг үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус төв нь Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Хөгжлийн шийдэл ТББ, Санхүү эдийн засгийн их сургууль, Эрүүл амьдралын жигүүр ТББ, Полиси судалгааны төв, Монгол Улсын Их Сургууль зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ЖИГҮҮР



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Банк нь 2030 он гэхэд нийт зээлийн багцад ногоон зээлийн эзлэх хувийг 10% хүртэл нэмэгдүүлэх зорилт тавьсан. Энэ зорилт нь Монгол Улсын санхүүгийн замын зурагтай нийцэж, санхүүжилтээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулахад чиглэж байна.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР



200.0 сая ам.долларын
БОНДЫГ

олон улсын зах зээлд
амжилттай арилжлаа.

Mitsubishi UFJ Financial Group (MUFG)-тэй хамтран боловсруулсан “Тогтвортой санхүүжилтийн хүрээ” -г тайлант онд эцэслэн, хөндлөнгийн үнэлгээ хийлгэснээр олон улсын зах зээлд ногоон бондыг амжилттай гаргалаа.

50.0 сая ам.долларын
эх үүсвэр

Монгол Улсын Ногоон таксономид тусгагдсан Тогтвортой, ногоон хөгжлийг дэмжсэн байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулж байгаагаараа онцлог юм.



Ногоон зээл

116.9 ▲ **118.2%**
тэрбум төгрөг 63,3 тэрбум төгрөг

2.288 ▲ **104.8%**
харилцагч 1,171 харилцагч

2.80% ▲ **1.27%**
Нийт зээлд
эзлэх хувь нэгж хувь




Тогтвортой
хөгжилд
ЧИГЛЭСЭН ЗЭЭЛ

384.6 ▲ **116.0%**
тэрбум төгрөг 206,5 тэрбум төгрөг

8.814 ▲ **99.8%**
харилцагч 4,402 харилцагч

9.21% ▲ **4.12%**
Нийт зээлд
эзлэх хувь нэгж хувь

- Төрийн банкны тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн багц 2025 оны эцсийн байдлаар 8,814 зээлдэгчийн 384.6 тэрбум төгрөг, үүнээс 2,288 зээлдэгчийн 116.9 тэрбум төгрөгийн ногоон зээлийн багцын үлдэгдэлтэй байна.
- Монгол улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлагдсан “Тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зураг”-г 2030 он гэхэд арилжааны банкууд нийт зээлийн багцын 10 хувийг ногоон зээл болгох зорилтыг тус тус тусгасан. Энэ хүрээнд Төрийн Банк нийт зээлийн багцын 10 хувийг ногоон зээл болгох зорилтыг дунд хугацааны стратеги төлөвлөгөөндөө тусгаад байна. Үүний үр дүнд ногоон зээлийн багц 2025 оны эцсээр 116.93 тэрбум төгрөгт хүрч, өмнөх жилээс 118.15 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН

Ногоон зээлийн бүтээгдэхүүн



Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны зээл. Уг зээл нь эрчим хүчийг 20 хувиас дээш хэмнэж буй орон сууц, амины орон сууцыг худалдаж авах, барих, засварлахад зориулагдсан бөгөөд 2025 онд 286 зээлдэгчид 36.2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.



Малчны ногоон зээл. Малын бэлчээрийн зүй зохистой ашиглалт, малын ашиг шим, үүлдэр угсаа, эрүүл мэндийг сайжруулах зориулалтаар малчин иргэдэд санал болгодог зээл бөгөөд 2025 онд 959 зээлдэгчид 20.0 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.



Эко тээврийн хэрэгслийн зээл. Эко тээврийн хэрэгслийн зээл нь иргэн, хуулийн этгээд өөрийн хэрэгцээнд зориулж банкт хамтран ажиллах гэрээтэй бэлтгэн нийлүүлэгчээс байгаль орчинд ээлтэй эко тээврийн хэрэгслийг худалдан авахад зориулагдсан зээл бөгөөд 2025 онд 341 зээлдэгчид 15.1 тэрбум төгрөгийн зээл олгосон.



Ахуйн хэрэглээний ногоон зээл, Ахуйн хэрэглээний цахим ногоон зээл. Ахуйн хэрэглээний ногоон зээлийг иргэн, хуулийн этгээд өөрийн хэрэгцээндээ зориулж эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан бараа, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, агаар хөрсний бохирдол бууруулах бараа бүтээгдэхүүн худалдан авахад зориулан олгодог бөгөөд 2025 онд 62 зээлдэгчид 656.1 сая төгрөгийн зээл олгосон.



Нийгмийн зээлийн бүтээгдэхүүн




Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл. Банк нь 2019 онд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийг зах зээлд нэвтрүүлсэн нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд хамгийн эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болсон. 2025 онд 2,113 зээлдэгчид 154.6 тэрбум төгрөгийн зээл олгож, бизнесийн үйл ажиллагааг бодитоор дэмжсэн төдийгүй ажлын байрыг нэмэгдүүлж, бизнесийн цар хүрээг нь тэлжээ.



Боловсролыг дэмжих зээл. Боловсролыг дэмжих зээлийг сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол, дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй иргэнд сургалтын төлбөр, дотуур байрны төлбөрөө төлөх, сургалтын хэрэглэгдэхүүн худалдаж авахад зориулж олгодог. 2025 онд 25 зээлдэгчид 771.9 сая төгрөгийн зээл олгосон.



Өрхийн бизнесийн зээл. Дундаж давхаргын иргэдийг дэмжих зорилгоор тодорхой хугацаанд бичил бизнес буюу жижиглэнгийн худалдаа, өрхийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн Улаанбаатар хотын болон орон нутгийн иргэдийг банкны бизнес инкубацын үйлчилгээнд хамруулж, санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх замаар бизнесээ амжилттай удирдахад нь дэмжлэг үзүүлсэн. Энэ хүрээнд Өрхийн бизнесийн зээлийг 220 зээлдэгчид олгож, нийт 8.9 тэрбум төгрөгөөр санхүүжилт олгосон байна.



Гарааны бизнесийн зээл. Дундаж давхаргыг дэмжих зорилгоор бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээд болон гарааны бизнес эхлүүлэхээр зорьж буй иргэн, аж ахуйн нэгжийг банкны инкубацын үйлчилгээнд хамруулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулж уг зээлийг олгодог. Тухайлбал, Улаанбаатар хот болон орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг банкны инкубацын үйлчилгээнд хамруулан бизнесийн болон санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл өгөх, үйл ажиллагааны эхлэлийн болон өсөлтийн мөчлөгөөс тогтворжих түвшинд хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх, технологийн шинэчлэлт хийх, тоног төхөөрөмж худалдаж авах, шинэчлэх, үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгө бэлтгэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж олгож байна. Энэ хүрээнд 2025 онд нийт 327 зээлдэгчид 36.0 тэрбум төгрөгийн зээл олгосон.

ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН



Тогтвортой, ногоон хөгжлийг дэмжих зорилгоор ногоон зээлийн нөхцөлийг уян хатан тогтоож, бүтээгдэхүүнийг төрөлжүүлээ. Төрийн банк Тогтвортой санхүүжилтийн хүрээнд хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд дараах бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүллээ. Үүнд:



Банктай хамтран ажиллаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, тогтвортой хөгжилд чиглэсэн бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулсан **“Ногоон бэлтгэн нийлүүлэгчийн зээл”**,



Хүн, байгаль орчинд ээлтэй, байгалийн нөөц баялгийг оновчтой ашигласан, эрчим хүч, усны хэмнэлт, ухаалаг хэрэглээг эрхэмлэсэн **“Ногоон орон сууцны зээл”**,



Бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан, тогтвортой хөгжилд чиглэсэн бизнесийн төслүүдийг санхүүжүүлэх зорилготой **“Бизнесийн ногоон зээл”**,



Банктай хамтран ажиллах гэрээтэй байгууллагууд эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарт ашиглах зориулалттай байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан, шинэ тоног төхөөрөмж эсвэл өөрөө явагч машин механизмыг гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд, төлбөртэйгөөр түрээслэгчийн эзэмшилд шилжүүлэх **“Ногоон санхүүгийн түрээс”**,



Бизнесийн зээлийг тогтоосон интервалын доод хүүгээр олгох зэрэг боломжуудыг агуулсан **“Ногоон харилцах данс”**.



БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН



Юнионпэй карт гаргагч байгууллагын Travel Mate Asia хөнгөлөлт урамшуулалд хамрагдах боломжтой, эмэгтэйчүүдэд зориулсан “Save green” кредит картаар дамжуулан мод тарих үйлсэд хувь нэмэр оруулж, 2025 онд шинээр 593 карт олгожээ.

“Эко боловсрол олгох аян”-ы хүрээнд “Хүрээлэн” төсөлтэй хамтран нэн ховор амьтдын зурагтай Эко картыг 2020 онд зах зээлд нэвтрүүлсэн. Байгаль, ан амьтан хамгаалахад хувь нэмэр болж буй уг ЭКО картыг өдгөө 32,771 харилцагч ашиглаж байна.



Монгол орон даяар мод тарих үйлсэд хувь нэмрээ оруулах зорилго бүхий 21 аймгийн үзэсгэлэнт байгалийн зураг бүхий **“Миний Монгол”** олон улсын виза картыг 2021 оноос харилцагчдадаа санал болгож, нийт **26,488** карт олгоод байна.



Эрүүл амьдралын хэв маягийг илэрхийлэх зорилготой, эрүүл мэндийн байгууллагуудаар хөнгөлөлттэй үйлчлүүлэх **“Эрүүл иргэн”** багц бүтээгдэхүүнийг **17,176** харилцагч хэрэглэж байна.



Тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн **“Ногоон даатгалын бүтээгдэхүүн”** -ийг зуучлан борлуулахаар МИГ даатгал ХХК, Мөнх даатгал ХХК, Хаан даатгал ХХК болон Ард даатгалын компаниудтай даатгалын зуучлалын нэмэлт гэрээг байгууллаа. Уг даатгалын бүтээгдэхүүнийг тайлант хугацаанд шинээр нэвтрүүлж, нийт **39.8 тэрбум** төгрөгийн үнэлгээтэй **487 зээлийг ногоон даатгалд хамруулсан** байна.



Грийн КУБ: Байгаль орчинд ээлтэй бараа бүтээгдэхүүн худалдан борлуулахаар банктай бэлтгэн нийлүүлэгчийн гэрээ байгуулсан ногоон бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад 0.6%-ийн шимтгэлтэй Грийн КУБ-ын үйлчилгээг санал болгож байна.



ХАМТРАН АЖИЛЛАЖ БУЙ НОГООН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД



Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл

Япон улсын Засгийн газар болон Монгол Улсын Сангийн яамтай хамтарсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл” буюу JICA төслийн зээлийг байгаль орчныг хамгаалах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих гэсэн хоёр үе шаттай олгодог. Энэхүү төсөл нь техник технологийн болон арилжаа, санхүүгийн хувьд найдвартай байх, эрүүл ахуй, аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт, байгаль орчны болон удирдлагын стандартад нийцсэн байдаг.

Төрийн банк 2006 оноос жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих 88 төслийн 41.4 тэрбум төгрөгийн зээл, байгаль орчныг хамгаалах 11 төслийн 5.9 тэрбум төгрөгийн зээл, нийт 94 төслийн 47.3 тэрбум төгрөгийн зээлийг тус тус санхүүжүүлээд байна.



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Байгальд ээлтэй хүүгийн хөнгөлөлттэй төсөл

Жилийн 9-13 хувийн хүүгийн татаастай “Байгальд ээлтэй хүүгийн хөнгөлөлттэй төсөл”-ийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран хэрэгжүүлж байна. Уг төсөл нь агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор цахилгаан халаагуур, дулаалгын материал, эко ариун цэврийн байгууламж, сайжруулсан зуух, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, цахилгаан тээврийн хэрэгсэл худалдан авах, хийн халаалтын төхөөрөмж худалдан авах, суурилуулах, нэвчилтгүй нүхэн жорлон, био жорлон худалдан авах болон суурилуулах, утаа шүүх яндан, яндангийн нэмэлт тоноглол, чип, дулаан шийдэл, ногоон амины орон сууц худалдан авах, бариулах зэрэг зориулалтаар зээл олгодог.

“Байгальд ээлтэй хүүгийн хөнгөлөлттэй төсөл”-ийн хүрээнд 2020 оноос хойш 357 зээлдэгчид 5.5 тэрбум төгрөгийн зээл олгосон.



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн зээлийг дамжуулан зээлдүүлэх төсөл

БОУАӨЯ-аас хэрэгжүүлж буй “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн зээлийг дамжуулан зээлдүүлэх төсөл”-ийн хүрээнд Тусгай хамгаалалттай бүс нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зээлийг Завхан, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл аймагт, Германы KFW байгууллагын санхүүжилтээр бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх буюу малын тоо толгойг нэмэгдүүлэхгүй байх зорилго бүхий зээлийг Хэнтий, Дорнод, Архангай, Хөвсгөл аймгийн харилцагчдад санал болгож байна.

Төслийн хүрээнд нийт 823 зээлдэгчид 7.5 тэрбум төгрөгийн зээл олгов.



БАЙШИН ДУЛААЛГЫН ЗЭЭЛ ДУЛААН ШИЙДЭЛ II ТӨСӨЛ 2022 – 2026



Улаанбаатар хот болон суурин газруудын агаарын бохирдлыг бууруулах, амины орон сууцны эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх нь Төрийн банкны тогтвортой хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэлүүдийн нэг юм. Энэ хүрээнд Төрийн банк нь Европын Холбооны "SWITCH-Asia" хөтөлбөрийн санхүүжилттэй "Дулаан шийдэл II" төслийн гол түншээр ажиллаж, Жэрэс (Geres) ОУТББ, ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүчний хэмнэлтийн төв (ВЕЕС), Монголын барилгын үндэсний ассоциаци (МБҮА), Монголын ногоон санхүүгийн корпорац (МНСК) болон Монголын эмэгтэйчүүдийн сан (МОНЭС) зэрэг байгууллагуудтай амжилттай хамтран ажиллаж байна.

Төслийн хүрээнд МНСК-иас хэмжих, тайлагнах, баталгаажуулах (MRV) тогтолцоог нэгтгэсэн "Дулаан байшин" ногоон зээлийн удирдамжийг боловсруулсан нь эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны санхүүжилтийг стандартчилах, нөлөөллийг хэмжих чухал суурь баримт бичиг болсон. Төрийн банк нь уг удирдамжид тулгуурлан ногоон зээлийн бүтээгдэхүүнээ хөгжүүлж, өмнө нь зөвхөн богино хугацаатай хэрэглээний зээл хэлбэрээр олгогдож байсан байшин дулаалгын санхүүжилтийг үнэ цэнийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын шинж чанартай болгон өөрчилсөн. Улмаар эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцанд зориулж 120 хүртэлх сарын хугацаатай, ногоон зээлийг зах зээлд нэвтрүүлсэн нь өрхийн санхүүгийн ачааллыг бууруулж, ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодит алхам болсон юм.

Түүнчлэн, үйл ажиллагаандаа хэмжих, тайлагнах, баталгаажуулах /MRV system/ тогтолцоог нэвтрүүлснээр ногоон зээлийн бүтээгдэхүүний байгаль орчин, нийгэм, жендэрт үзүүлэх үр нөлөөг тоон үзүүлэлтээр бодитой хэмжих, тайлагнах, баталгаажуулах боломж бүрдсэн. Ийнхүү "Дулаан шийдэл II" ногоон зээл нь зөвхөн санхүүгийн бүтээгдэхүүн төдийгүй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг хослуулсан шийдэл болж, Монгол Улсад тогтвортой хэрэглээг дэмжих, бодлогын түвшний шилжилт хийхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

МОНГОЛ ГЭРИЙН ДУЛААЛГА -CHIP ТӨСӨЛ



Гэр хорооллын өрхүүдийн амьдрах орчныг сайжруулах, нүүрсний хэрэглээнээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд Төрийн банк нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сан (UNICEF)-гийн санаачилсан "Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП багц" хөтөлбөрийн гол түнш байгууллагын хувиар оролцож, зорилтот өрхүүдэд ногоон зээлийг хүртээмжтэй, уян хатан нөхцөлөөр олгож байна.

ЧИП хөтөлбөрийг UNICEF-ийн санхүүжилт, техникийн дэмжлэгтэйгээр "Пипл Ин Нийд" (PIN) ОУТББ, ШУТИС-ийн Барилгын Эрчим Хүчний Хэмнэлтийн Төв (ВЕЕС), Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС Холбоо) зэрэг байгууллагууд 2019 оноос хойш хамтран амжилттай хэрэгжүүлж байна. Энэхүү олон талт түншлэлийн үр дүнд 2025 оны байдлаар 6,000 гаруй өрх CHIP шийдлийг нэвтрүүлж, үүнээс 400 гаруй өрх ногоон зээлийн санхүүжилтээр багцыг худалдан авч, нүүрсний хэрэглээнээс бүрэн татгалзсан нь бодит нөлөөллийн чухал үзүүлэлт болж байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Банк Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого болон Тогтвортой хөгжлийн журамд тодорхойлсон зарчим, зохицуулалтыг ханган ажиллаж байна. Тогтвортой санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлт болон Зээлийн бодлогод тодорхойлсон үндсэн зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд банк зээл олгож буй харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм засаглалын эрсдэлийг үнэлж, сайжруулах, хянах, тайлагнах замаар эрсдэлийг үр дүнтэй удирдахыг зорьж ажилладаг.

БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний процессын зохицуулалт, банкны санхүүжүүлэхийг хориглох үйл ажиллагаа болон байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө бүхий зарим эдийн засгийн салбарт зээлийн багцын хязгаарлалт тавих зэрэг эрсдэлийн удирдлагын зохицуулалтуудыг банк "Тогтвортой хөгжлийн журам"-даа тусгасан.

Банк эдийн засгийн салбаруудыг байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн түвшнээс хамааруулан өндөр, дунд, бага нөлөөлөлтэй гэж ангилдаг. Өндөр, дунд нөлөөлөл бүхий эдийн засгийн салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулж буй харилцагчийн 150.0 сая төгрөг ба түүнээс дээш дүнтэй бүх бизнесийн зээлийн хүсэлтэд БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн шинжээчид хийдэг. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн хувьд эрсдэл учрах магадлал, үр нөлөө, цар хүрээг харгалзан ОУСК-ийн гүйцэтгэлийн стандартын агуулгын хүрээнд үнэлдэг.

Үнэлгээний үр дүнд тухайн харилцагчийн БОНЗ-ын эрсдэлийг бууруулах, үл нийцлийг арилгах зорилгоор сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг зээлийн гэрээний үүрэг болгож боловсруулдаг бөгөөд

тухайн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин, үр дүн буюу харилцагчийн БОНЗ-ын эрсдэл хэрхэн буурсныг тодорхойлох хяналтын үнэлгээг давхар хийж байна.

БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээг тодорхойлох тухай зохицуулалтад өөрчлөлт оруулах, шинэчлэх асуудлыг Тогтвортой хөгжлийн хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байгаа бөгөөд 2025 онд БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ хийх зээлийн хүсэлтийн дүнг 150 сая төгрөгөөс дээш болгон өөрчлөн хэрэгжүүлж ажилласан.

Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ хийснээр зээлдэгчийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй байгаль орчин, нийгэм болон удирдлагын эрсдэлийг урьдчилан тодорхойлж, хариуцлагатай санхүүжилтийн олон улсын зарчим, шаардлагад нийцэх боломжийг бүрдүүлдэг.


2025
онд

333 харилцагчийн
172.6 тэрбум ₮-н зээлд

БОНЗ-ын
эрсдэлийн
үнэлгээ
хийсэн.

2024 онтой харьцуулахад харилцагчийн тооны хувьд 100, үнэлгээний дүнгийн хувьд 74 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

БОНЗЭУ хийсэн зээлийн багц, эдийн засгийн салбараар 2025



ТАЙЛАГНАЛ



ТАЙЛАГНАЛ

Төрийн банк нь Тогтвортой хөгжлийн тайланг нийт гурван удаа олон нийтэд нээлттэй тайлагнасан бөгөөд цаашид тайлангийн агуулгыг илүү өргөжүүлж, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагааны мэдээллийг багтаан сайжруулж байна.



Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын шалгуур үзүүлэлт бүхий “Ногоон таксономи”-г 2019 онд баталсан. Банк тус 8 ангиллын дагуу ногоон зээлийн олголт, төлөлт, үлдэгдлийн мэдээг улирал бүр, БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийн тайланг хагас жил бүр, бондын эх үүсвэрийн тайланг улирал бүр тус тус Монголбанканд тогтмол тайлагнаж байна.



Бид Тогтвортой санхүүжилтийн холбоонд хагас жил бүр сайн дурын үндсэн дээр Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлаа тогтмол тайлагнаж байна. Уг тайлангаар тогтвортой санхүүжилтийн менежментийн систем, байгаль орчин ба нийгмийн менежментийн систем, зээлд байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал, ногоон зээл олгосон байдал болон ToC-ийн 8 зарчмын дагуу хийгдсэн ажлуудыг тайлагнадаг.



Төрийн банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор 2023 оноос эхлэн зохицуулагч байгууллагаас гаргасан удирдамжийн дагуу “Байгаль орчин, нийгэм засаглалын тайлан”-г Монголын хөрөнгийн биржид 3 дахь жилдээ хүргүүлэв.



НҮБ-ын Даян дэлхийн гэрээний оролцогчийн хувьд банкны үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцүүлсэн байдал, ахиц дэвшлийн талаарх “Communication on Progress” тайланг хоёр дахь жилдээ бэлтгэн хүргүүлээ.

Хавсралт. СТОУС ТБ 1

Багана	Дэд хэсэг	Үзүүлэлтүүд	Эх сурвалж	ТоХ-ийн тайлан ба БОНЗ-ын тайлан хуудас
Байгууллагын тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжуудад хяналт тавих үүрэгтэй засаглал хариуцсан бүрэлдэхүүн (үүнд төлөөлөн удирдах зөвлөл, түүнтэй адилтгах засаглал хариуцсан бүрэлдэхүүн) эсвэл хувь хүн(хүмүүс) байна.	27а	Аж ахуйн нэгж нь тухайн байгууллага(ууд) эсвэл хувь хүн(хүмүүс)-ийг тодорхойлж, дараах мэдээллийг толилуулна:		
		Тухайн бүрэлдэхүүн(үүд) эсвэл хувь хүн(хүмүүс)-тэй хамааралтай ажлын эрх үүргийн тодорхойлолт, хариуцлага болон бусад холбогдох бодлогуудад тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжтой холбоотой үүрэг хариуцлагуудыг хэрхэн тусгасан талаар;	Тогтвортой Хөгжлийн тайлан 2025, БОНЗ-ын тайлан 2025: Компанийн засаглал	Хуудас 11
		Тухайн бүрэлдэхүүн (үүд) эсвэл хувь хүн(хүмүүс) нь тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжид хариу арга хэмжээ авахад чиглэсэн болон стратегийн хэрэгжилтийг хянахад шаардагдах зохих үр чадвартай эсэх, эсвэл уг үр чадвараа хөгжүүлэхээр төлөвлөж буй;		
	Тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжтой холбоотой мэдээлэл тухайн байгууллага(ууд) эсвэл хувь хүн(хүмүүс)-д хэрхэн болон хэр тогтмол хүрдэг вэ;			
	Тухайн бүрэлдэхүүн (үүд) эсвэл хувь хүн(хүмүүс) нь байгууллагын стратеги, томоохон ажил гүйлгээний шийдвэр, эрсдэлийн удирдлагын процесс, холбогдох бодлогод хяналт тавихдаа тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийг хэрхэн харгалзан үздэг, (үүнд тухайн бүрэлдэхүүн (үүд) эсвэл хувь хүн(үүс) нь тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийн ацан сонголтыг хэрхэн авч үзсэн талаар;			
	Тухайн бүрэлдэхүүн (үүд) эсвэл хувь хүн(хүмүүс) нь тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийн зорилтуудыг тодорхойлоход хэрхэн хяналт тавьж, тэдгээр зорилтод хүрэх явцыг хэрхэн хянадаг, үүнд холбогдох гүйцэтгэлийн хэмжүүрүүд нь цалин хөлсний бодлогод хэрхэн тусгагдсан зэрэг			
	27б	Тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийг удирдах, хянахад ашигладаг засаглалын процесс, хяналт, журамд удирдлагын гүйцэтгэх үүрэг, оролцоо, үүнд:		
		тодорхой удирдлагын түвшний албан тушаал эсвэл удирдлагын түвшний хороо(нуудад) үүрэг хариуцлагуудыг хуваарилалт хийсэн эсэх мөн тухайн албан тушаал, хороонд хэрхэн хяналт тавьж байгаа талаар;		
Байгууллагын удирдлага нь тогтвортой байдалд хамаарах боломж, эрсдэлийн хяналтыг дэмжихийн тулд ямарваа нэг хяналт, журмыг ашиглаж байгаа эсэх, хэрэв тийм бол эдгээр хяналт, журмыг бусад дотоод бүтэц, чиг үүрэгүүдтэй хэрхэн нэгтгэж байгаа талаар				
Стратеги				
Стратегийн тогтвортой байдалтай холбоотой санхүүгийн тайлагналын зорилго нь нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийг удирдахад ашиглагдаж буй удирдлагын стратегийг ойлгоход туслахад оршино.	29	Байгууллага нь санхүүгийн тайланг ашиглаж буй хэрэглэгчдэд байгууллагын талаарх доорх зүйлсийг ойлгох боломж олгох үүднээс тодруулга бэлдэнэ:	Тогтвортой Хөгжлийн тайлан 2025: Стратеги, Материаллаг сэдвүүд	Хуудас 16, 27
		Байгууллагын хэтийн төлөвт нөлөөлж болзошгүй тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломж;		
		тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийн аж ахуйн нэгжийн бизнесийн загвар болон үнэ цэний гинжин хэлхээнд үзүүлэх одоогийн болон хүлээгдэж буй үр нөлөө;		
		тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжтой холбоотойгоор байгууллагын стратеги болон шийдвэр гаргахад үзүүлэх нөлөө;		
		тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийн тайлант үед болон богино, дунд, урт хугацаанд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээнд үзүүлсэн, эсвэл хүлээгдэж буй үр нөлөө, тэдгээрийн байгууллагын санхүүгийн төлөвлөлтөд хэрхэн тусгасныг харгалзан үзэх;		
аж ахуйн нэгжийн стратеги болон бизнесийн загвар нь тогтвортой байдалд хамаарах эрсдэлүүдэд тэсвэртэй байдал.				
Тогтвортой байдалтай холбоотой эрсдэл болон боломж	30	Аж ахуйн нэгж нь нийтлэг зориулалттай санхүүгийн тайланг хэрэглэгчдэд аж ахуйн нэгжийн хэтийн төлөвт нөлөөлөхүйц тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийг ойлгох боломжийг олгоход нь туслах мэдээллийг агуулах ёстой. Тодруулбал, аж ахуйн нэгж нь:	Тогтвортой Хөгжлийн тайлан 2025: Материаллаг сэдвүүд	Хуудас 27
		Аж ахуйн нэгжийн хэтийн төлөвт нөлөөлж болзошгүй тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийг тайлбарлах;		
		Тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломж тус бүрийн хувьд богино, дунд эсвэл урт хугацааны алинд гарж болох, болон тэдгээрийн боломжит үр нөлөөг тодорхойлох;		
	Байгууллага "богино хугацаа", "дунд хугацаа" болон "урт хугацаа"-г хэрхэн тодорхойлсон болон эдгээр тодорхойлолтууд нь стратегийн шийдвэр гаргахад ашигладаг төлөвлөгөөний мөчлөгтэй хэрхэн уялдаж байгааг тайлбарлах.			
31	Богино, дунд, урт хугацааны мөчлөг нь байгууллагаасаа хамаараад харилцан адилгүй байж болно. Тухайлбал, мөнгөн урсгал, хөрөнгө оруулалт, бизнесийн мөчлөг болон тухайн салбарын онцлог шинж чанар, хөрөнгийн хуваарилалтын төлөвлөгөө, нийтлэг зориулалттай санхүүгийн тайланг ашиглаж буй хүмүүс хэзээ дунджаар салбарын компаниудын шинжилгээ хийж үнэлгээ өгдөг, зэрэг олон хүчин зүйлсээ шалтгаална.			

Хавсралт. СТОУС ТБ 1

Багана	Дэд хэсэг	Үзүүлэлтүүд	Эх сурвалж	ТоХ-ийн тайлан ба БОНЗ-ын тайлан хуудас
Бизнесийн загвар болон үнэ цэний гинжин хэлхээ	32	Байгууллага нь нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан уншигчдад аж ахуйн нэгжийн өнөөгийн болон хэтийн бизнесийн загвар болон үнэ цэний гинжин хэлхээнд нөлөөлж болзошгүй тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийг ойлгоход туслах мэдээллийг тайлагнана. Тодруулбал, аж ахуйн нэгж дараах мэдээллийг толилуулна.		
		Байгууллагын бизнесийн загвар болон үнэ цэний гинжин хэлхээнд тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийн одоогийн болон хүлээгдэж буй нөлөөллийн тодорхойлолт;	Тогтвортой хөгжлийн тайлан-2025: Стратеги, Материаллаг сэдвүүд	Хуудас 16, 27
		Байгууллагын бизнесийн загвар болон үнэ цэний гинжин хэлхээнд Тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломж хаана голлон гарч байгааг тодорхойлж тайлбарлах (жишээлбэл, газарзүйн бүс, байгууламж, хөрөнгийн төрөл).		
Стратеги болон шийдвэр гаргалт	33	Байгууллага нь нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан уншигчдад аж ахуйн нэгжийн стратеги болон шийдвэр гаргалт дахь тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийн нөлөөг ойлгоход туслах мэдээллийг тайлагнана. Тодруулбал, доорх зүйлсийг тайлагнана.		
		Байгууллага нь стратеги болон шийдвэр гаргалтдаа тогтвортой байдалтай холбоотой эрсдэл, боломжийг хэрхэн тусгаж, ямар хариу үйлдэл үзүүлдэг, эсвэл ямар хариу үйлдэл үзүүлэхээр төлөвлөж байгаа;	Тогтвортой хөгжлийн тайлан-2025: Стратеги, Тогтвортой санхүүжилт, БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ	Хуудас 16, 61, 69
		тоон болон чанарын мэдээллийг багтаасан өмнөх тайлант жилийн хугацаанд байгууллагын төлөвлөгөөний дагуух ахиц дэвшил;		
		байгууллагын харгалзаж үзсэн тогтвортой байдалд хамаарах эрсдэл ба боломжийн ацан сонголт (жишээлбэл, шинэ үйл ажиллагаа явуулах байршлын талаар шийдвэр гаргахдаа тухайн байгууллага үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон нийгэмд бий болгох ажлын байрыг харгалзан үзэх).		
Санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйцэтгэл	35	Тодруулбал, Байгууллага нь:		
		Тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломж нь тайлант үед санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн урсгалд хэрхэн нөлөөлсөн;	Тогтвортой хөгжлийн тайлан-2025: Санхүүжилтийн эх үүсвэр	Хуудас 62
		дараагийн тайлант жилд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг өөрчлөлт оруулах боломжтой 35(а)-д тодорхойлсон тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийн талаар тоон болон чанарын мэдээллийг тайлагнана;		
		Тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийг удирдах стратегитай холбоотойгоор тухайн байгууллагын богино, дунд, урт хугацааны санхүүгийн байдал яаж өөрчлөгдөхийг таамаглахдаа доорх хүчин зүйлсийг авч үзнэ:		
		холбогдох гэрээ байгуулсан эсхийг үл харгалзан хөрөнгө оруулалт болон худалдан борлуулах төлөвлөгөө (жишээлбэл, хөрөнгө оруулалтын зардал, томоохон худалдан авалт, хөрөнгө оруулалт, хамтарсан хөрөнгө оруулалт, бизнесийн өөрчлөлт, инновац, бизнесийн шинэ чиглэл, хөрөнгө ахлах төлөвлөгөө);		
		стратегийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэр;		
Тогтвортой байдалд хамаарах эрсдэл, боломжийг удирдах стратегитай холбоотойгоор тухайн байгууллагын богино, дунд, урт хугацааны санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн урсгалд орох өөрчлөлтийн төсөөлөл.				
Эрсдэлийн удирдлага		Эрсдэлийн удирдлага		
Эрсдэлийн удирдлагын талаар тогтвортой байдалд хамаарах санхүүгийн тодруулгын зорилго нь санхүүгийн тайлан хэрэглэгчдийг дараах боломжоор хангах юм:	43	Аж ахуйн нэгжийн ерөнхий эрсдэлийн үнэлэмж ба түүний ерөнхий эрсдэлийн удирдлагын процессыг үнэлэх.		
		Тогтвортой байдалд хамаарах эрсдэл болон боломжийг байгууллага хэрхэн тодорхойлж, үнэлж, эрэмбэлж, хянаж байгааг ойлгох бөгөөд үүнд эдгээр үйл ажиллагаанууд нь байгууллагын нийт эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд нэгтгэгдсэн эсэх, ямар байдлаар нэгтгэгдсэн зэрэг мэдээлэл хамрагдсан байна;	Тогтвортой хөгжлийн тайлан-2025: Эрсдэлийн удирдлага	Хуудас 30
		Байгууллагын нийт эрсдэлийн байдал болон нийт эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг үнэлэх.		

Хавсралт . СТОУС ТБ 1

Багана	Дэд хэсэг	Үзүүлэлтүүд	Эх сурвалж	ТоХ-ийн тайлан ба БОНЗ-ын тайлан хуудас
Эрсдэлийн удирдлагын талаар тогтвортой байдалд хамаарах санхүүгийн тодруулгын зорилго нь санхүүгийн тайлан хэрэглэгчдийг дараах боломжоор хангах юм:	44	Энэхүү зорилгод хүрэхийн тулд байгууллага нь дараах мэдээллийг тайлагнах шаардлагатай:		
		Байгууллагын тогтвортой байдалд хамаарах эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх болон хянахад ашигладаг үйл ажиллагаа болон холбоотой бодлогууд. Үүнд дараах хамаарна:		
		Байгууллагын хэрэглэдэг орц болон параметрууд (жишээлбэл, өгөгдлийн эх сурвалжийн талаарх мэдээлэл, үйл ажиллагаанд орж буй ажлуудын цар хүрээ)	Тогтвортой хөгжлийн тайлан-2025: Эрсдэлийн удирдлага, БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ	Хуудас 30, 69
		Байгууллага нь тогтвортой байдалд хамаарах эрсдэлийг тодорхойлохдоо сценари шинжилгээ ашигладаг эсэх, хэрхэн ашигладаг талаар;		
		Тэдгээр эрсдэлийн шинж чанар, магадлал болон нөлөөллийн хүчийг байгууллага нь хэрхэн үнэлдэг (жишээлбэл байгууллага нь чанарын хүчин зүйлс, тоон хязгаар эсвэл бусад шалгууруудыг авч үздэг эсэх);		
		Байгууллага нь тогтвортой байдалд хамаарах эрсдэлийг бусад төрлийн эрсдэлүүдээс чухалчилж авч үздэг эсэх, хэр чухалд эрэмбэлдэг		
		Байгууллага нь тогтвортой байдалд хамаарах эрсдэлүүдийг хэрхэн хянадаг;		
		Өмнөх тайлант хугацаатай харьцуулахад байгууллага нь процессоо өөрчилсөн эсэх, ямар өөрчлөлт хийсэн талаар;		
Байгууллагын тогтвортой байдалд хамаарах боломжийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх болон хянахдаа ашигладаг үйл ажиллагаанууд;				
Тогтвортой байдалд хамаарах эрсдэл болон боломжийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх, хянах үйл ажиллагаанууд нь байгууллагын нийт эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хэр их хэмжээнд болон хэрхэн нэгтгэгдсэн талаар				
Хэмжүүр болон Зорилт		Хэмжүүр болон Зорилт		
Хэмжүүр болон Зорилтын талаар тогтвортой байдалд хамаарах санхүүгийн тодруулгын зорилго нь санхүүгийн тайлан хэрэглэгчдийг байгууллагын тогтвортой байдалд хамаарах эрсдэл болон боломжийн хүрээнд ямар гүйцэтгэлтэй байгааг мэдэх боломжоор хангах бөгөөд үүнд байгууллагынхаа хүрээнд тавьсан болон хууль, журмын шаардлагын зорилтуудын хүрээнд байгууллагын гаргаж буй дэвшил зэрэг мэдээлэл хамрагдсан байна.	46	Байгууллагын хэтийн төлөвт нөлөө үзүүлж болохуйц тогтвортой байдалд хамаарах эрсдэл болон боломж нэг бүрийг байгууллага нь тайлагнах хэрэгтэй:		
		Холбогдох СТОУС Тогтвортой байдлын ил тод тайлагнах стандартуудын дагуу шаардагддаг хэмжүүрүүд		
		Байгууллагын дараах зүйлсийг хэмжих, хянахдаа ашигладаг хэмжүүрүүд:		
		Тогтвортой байдалд хамаарах эрсдэл эсвэл боломжийг;	БОНЗ-ын тайлан-2025:	
	Тогтвортой байдалд хамаарах эрсдэл эсвэл боломжийн хүрээнд ямар гүйцэтгэлтэй байгааг, үүнд байгууллагынхаа хүрээнд тавьсан болон хууль, журмын шаардлагаар тавьсан зорилтуудынхаа хүрээнд гаргаж буй дэвшил зэрэг орно.			
	51	Байгууллага нь стратегийн зорилгуудаа хүрэх явцын үр дүнг хянахын тулд тодорхойлсон зорилтууд болон хууль, журмын дагуу шаардагддаг зорилтуудын талаар мэдээллийг тайлагнана. Зорилт тус бүрээр дараах мэдээллийг тайлагнана:	Тогтвортой хөгжлийн тайлан-2025: Бидний тогтвортой хөгжлийн замнал, Тогтвортой санхүүжилт	Хуудас 24, 61
		Хууль, журмын дагуу шаардагддаг буй болон байгууллага өөрөө тодорхойлж тавьсан тоон болон чанарын тусгай зорилтууд;		
		Тухайн зорилтод хамаарах хугацаа;		
		Явцын үр дүнг хэмжиж эхэлсэн суурь хугацаа;		
	Аливаа чухал хугацаа болон явцын дундах түр/завсрын зорилтууд;			



☎ 1800-1881

🌐 www.statebank.mn

📘 /StatebankMN

📺 /StatebankMN



АВИЛГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД



1-110

Гомдол, мэдээлэл
хүлээн авах утас